

“Миний худалдаж авсан нөхөр” орчуулгын өгүүллэг

Ayn Rand-н зохиол

"The husband I bought"-г орчуулга

Би энэ өгүүллэгийг бичих учиргүй байсан юм...

Зөвхөн чив чимээгүй байснаараа л би энэ бүхнийг даван туулсан. Өөрийгөө дуугүй байлгахийн тулд магадгүй энэ хорвоо дээрхи ямар ч бүсгүй туулж гараагүй тэр их зовлонг би тэссэн юм. Харин одоо- Би яриж эхлэхээр шийдсэн. Үнэндээ одоо нууцаа дэлгэх нь ямар ч утгагүй ч гэсэн надад итгэл найдвар байсаар байгаагаа би саяхан мэдсэн юм. Миний эцсийн ганцхан найдвар. Надад одоо их цаг үлдээгүй байгаа. Амьдрал хов хоосорч, эрлэгийн үүдэн дээр оччихоод байхад хамгийн эцсийнхээ боломжийг ашигласныг минь буруутгах хүн гарахгүй гэж би найднам. Бүх юм дуусахын өмнөх ганцхан боломж... Тийм учраас би энэхүү нууцаа бичэхээр шийдсэн юм.

Би Гэнрид хайртай байсан. одоо ч хайртай. Өөрийнхөө тухай өнгөрсөн амидралийнхаа тухай хэлж чадах ганцхан юм маань гэвэл юрдөө л энэ. Миний амьдрал гэвэл юрдөө л Гэнри. Энэ хорвоо дээр хайрлаж дурлаж үзээгүй хун нэгээхэн ч үгүй биз ээ! Гэхдээ хайр гэгч чиний ухаан санаа, зүрх сэтгэл гээд бүхэл хил хязгаарыг төвөггүй давж чаддаг юм билээ.

Би түүнтэй хэрхэн танилцаж байснаа огт боддоггүй юм. Надад угаасаа чухал ч биш. Би түүнтэйгээ уулзах учиртай л байсан, тэгээд л бид учирсан. Хэзээ, яж ягаад түүнийг хайрлаж эхэлсэн, хэрхэн түүнийг хайрладагаа ухаарсаныгаа бол бүүр ч мэдэхгүй. Миний мэдэх юм гэвэл амьдрал маань 2хон үгнээс бүрдэж байсан: "Гэнри Стаффорд". тэр өндөр туранхай, бас хэтэрхий үзэсгэлэнтэй хүн байсан юм. Тэр маань асар их хүсэл тэмүлэлтэй байсан ч тэрийгээ хэзээ нэг цагт анзаарч байсан гэж

боддоггүй. Байгалиас л тэр чигээрээ төрсөн хун байсан. Үргэлжилсэн их хвсэл мөрөөдөл түүнд бурхнаас заясан байсан юм. Гэнри миний л мэдэх хамгийн тогс төгөлдөр, ухаалаг эр. Бүхэл хамт олон даяраа түүнийг гайхан бишэрдэг байхад тэр бусад хүмүүсийг шоглон хөхөрч чаддаг байлаа. Бага зэрэг залхуу, бас няхуур. Гэхдээ түүнийг юу ч цочроож чадахгүй. Өөртөө шүүмжлэлтэй бас итгэлтэй ханддаг ч бусадтай тохуурхангуй ихэмсэг байдлаар харьцдаг байсан юм.

Мэдээж манай жижиэгхэн хотын охин бүр түүн рүү хошуурдаг байлаа. Тэр хүн бүртэй нээлттэй сээтгэнэдэг байсан нь охидийг галзууруулах дөхдөг байв. Гэнри-н аав нь түүнд томоохон бизнес орхисоныг Гэнри зовлон төвөг багатай ч хангалттай мөнгө олж чадахуйцаар зохицуулан эрхэлдэг байжээ. Тэр нийгэм хамт олонтойгоо харьцахдаа, хатагтай нартай сээтэгнэхдээ, ном сонин уншихдаа гаргадаг эелдэг байдал, төгс тоомжиргүй байдлаараа бизнесээ эрхэлдэг байсан.

Ноён Барнс- бас ахисан хуульч, хуучин анд маань нэг удаа "Тэр боломжгүй залуу... Би түүний хайрлах бүсгүйд атаархана... харин түүнтэй гэрлэх бүсгүйг өрөвдөнө." гэж их л бодлогоширонгуй дуугаар надад хэлж байсан юм. Тухайн үедээ бол би ганц нён Барнсын ч биш олон хүний атаархалыг төрүүлсэн: Гэнри Стаффорд намайг хайрласан. тэгэхэд би дөнгөж 21 настай, хамгийн сайн их сургуулиудын нэгийг төгсчихөөд байсан юм. Би эцэг эхийнхээ үлдээсэн үзэсгэлэнтэй эдлэн газарт, уугуул хотдоо ирж амьдрахаар шийдсэн маань ямар ч учиртай байсан юм бэ дээ. Ойрын ямар ч хамаатангүй надад үлдсэн тэр эдлэн газар том, тансаг, бас сайхан том цэцэрлэгтэй байлаа. Би тэндээ өөрөө өөрийнхөөрөө амидарсаар бүр дасчихсан байв.

Энэ өгүүлэлтээ би хамаг л үнэнийг хэлж байгаа учраас би өөрийгөө үзэсгэлэнтэй сайхан байсан гэдгээ ч хэлэх хэрэгтэй болов уу! Бас бусдаас илүү цэцэн цэлмэг гэдгээ ч би мэддэг байсан юм. Ер нь ухаалаг хүн өөрийнхөө ухалагийг яж ч байсан мэддэг шүү дээ. Хүмүүс бүгд л намайг "Дэндүү сайхан ухаалаг охин" "асар их ирээдүйтэй бүсгүй" гэлцдэг байсан ч гэсэн миний өөрийнхөөрөө зан-д маань нэг их дуртай байгаагүй ши сангддаг.

Би Гэнри Стаффорд-д хайртай байлаа. Миний насныхаа эцэст ойлгож авсан зүйл бол ердөө л энэ. Тэр миний амьдрал байсан юм. Хэзээ нэгэн цагт өөр хүнийг хайрлаж чадахгүй гэдгээ би үргэлж мэддэг байсан. Тэр маань ч үнэн байжээ. Магадгүй хүн хүнээ тэгж их хайрлаж болохгүй, дэмий байдаг байх. Гэхдээ одоо хэнбэ гуайи ч надад тэгж хэлээд нэмэргүй болжээ: тэр миний амьдрал байсан юм байж.

Стаффорд ч надад хайртай байсаан. Бүүр чин сэтгэлээсээ. Энэ бол түүний амьдралдаа анх удаа инээлгүйгээр харсан зүйл нь байсан юм. "Би өөрийгөө хайрын өмнө ийм хүчин мөхөс амьтан болчихно гэж хэзээ ч боддоггүй байжээ" гэж тэр маань заримдаа зөөлхөн хэлдэг байв. "Чи минийх байх учиртай, Иринэ. ягад гэвэл би өөрийнхөө хүссэн бүгдийг авах гэж хорвоод төрсөн хүн. Харин чи бол миний хорвоогоос хүсэх цорын ганц зүйл." гээд гарын маань хурууны өндөгнөөс мөр хүртэл маань үнсэж байсныг нь би мартдаггүй юм.

Би бол түүн рүү харахдаа энэ хорвоо дээр өөр юг ч мэдэрч чадахаа больдог байлаа. Түүний хөдлөж байгаа нь, ааш аяг нь дуу хоолой нь гээд бүгд л намайг чичрүүлж орхидог... Үүн шиг их сэтгэлийн хөдлөл, хүсэл биед чин нэг орчихвол хэзээ ч гардаггүй юм билээ. Сүүлчийн чин амисгал л үүний төгсгөл болно. Энэ мэдрэмж чиний биеийг чин шатаж дуустал оршино. Дахин шатах юу ч үлдээгүй байхад ч тэр мэдрэмж бадамлан ассаар л байх болно. Тэгээд л аз жаргал эхлэнэ дээ. Дэндүү их жаргал...

Би нэг өдрийг бүүр аягуй тод санаж байна. Үер усаар ямар баян байдаг билээ дээ... Яг л тийм их нартай нэгэн өдөр байсан юм. Тэр бид 2 дүүжин даажин дээр тоглож байлаа. Бид 2 цав цагаан хувцастай, урт нарийн тавцангийн 2 талд нь зогсчихсон, олсноос гараараа чанга гэгч нь атгачихсан нэг талас нөгөө тал руу нисэх мэт савлуурдаж байлаа. Бид маш хурдан савлаж байснаас болоод олс хачин этгээд дуу гаргаж, би бүүр амьсгалж ч чадахгүй болчихсон байсан юм. Дээшээ... Дооошоо... Дээшээ... Дооошоо... Дэрэвгэр банзал маань өвдөгнөөс ч дээш гарч нисэн байхад тэр маань "илүү хурдан, илүү хурдан" хэмээн хашигарч байлаа. "Дээшээ... Гэнри дээшээ..." гэж би хариулсан. ТСамц нь цээж онгорхой, ханцуйгаа

тохой хвртлээ шуучихсан тэр маань ямар ч вэсгэлэнтэй харагдаж байгаав дээ...Гараараа олсноос барьчихсан тvvний хөнгөн шингэн хөдөлгөөн, хvчтэй уян бие нь савлуурыг дор нь л хөдөлгөчихөж байлаа. Үс н; салхинд намираад л...

Амьсгалж ч чадахгvй, тэр хурц наранд байхдаа би өмнөө байгаа залуугаас өөр юуг ч мэдрэхгvй байж билээ. ДАраа нь хэн хэндээ юу ч хэлэгvйгээр савлуурын хамгийн өндөр цэгээс хамаг хурдаараа всрэн буусан. Газарт унахдаа бид 2 гар хөлөө бяцхан шалбалцгаасан боловч тэр тухай хэн маань ч бодох сөхөө байсангvй. Тэр намайг тэвэрч савлуур дээр байхад ч мэдрэгдээгvй тэр их галзууралтайгаар внссэн юм. Энэ нь бидний анхны удаа внсэлцэж байсан явдал биш боловч, би тэр внсэлтийг хэзээ ч мартахгvй. Тvvний гарт байгаагаа бодохоор би бараг ухаан алдчихаж байлаа. Би тvvний мөрийг чанга гэгч нь базаж (урт хумс маань цусийг нь гартал хvчтэй базсан байлаа.) тvvнийгээ внссэн. Дараа нь хvзvvг нь... цамцных нь онгорхой заханд хуртэл унссэн...

Тэр уед бидний бие биэндээ хэлсэн ганц л vг нь тvvнээс гарсан байлаа... Зөөлхөн шивнээ... "Үүрд ийм байна гэж хэлээч... Иринэ... Үүрд".

Дараагийнх өдөр тэр ирсэнгvй. Үдэш хvртэл сэтгэлээ чилээн хвлээлээ. Байхгvй. Дарагийн өдөр нь ч бас тэр узэгдсэнгvй. Харин миний зvгээс жаахан ч болов анхаарал татахыг хvсэн явдаг, өөртөө итгэлтэй нэгэн залуу дарах өдөр нь намайг дуудаж янзан бvрийн юмны тухай эцэс төгсгөлгvй мэт юмс ярисаар байснаа сvйлд нь "Нээрээ сониноос, Гэнри Стаффордын бизнес аюлд учирсан гэнэ лээ. Их л чухал хэцvv юм болсон гэж хvmvvc ярилцацгаах юм билээ." гэж хэллээ. Маргааш нь би тэр муухай мэдээг бvхнээр нь сонсож билээ: Гэнри бvvр зvйрч дууссан байлаа. Тэр өөрөө юу ч vгvй хоосроод зогсоогvй, маш олон хvнд хувь заяа, асар их мөнгө төлөх учиртай влдсэн байлаа. Гэхдээ энэ нь тvvний буруу биш байжээ... Зvгээр л болчихсон юм байж. Хvн бvр тэрийг нь мэдэж байсан хэрнээ бvгд л тvvнийг буруутгаж байв. Тэр дампууралтай хамт тvvний нэр төр, ажил хэрэг, ирээдvй бvгд нь шалбаагт унасан юм.

Түүний кимпань свйрсэн нь мания хотынхныг хэсэгтээ л баясгаж байв. Зарим нэг нь Гэнри-г өрөвдөх боловч, ихэнх нь баяртай байлаа. Хүмүүс Гэнри-г хүндэлдэгийнхээ зэрэгцээгээр атаархдаг байж... эсвэл тэд түүнийг хүндэлдэг болохоороо ч атаархдаг байсан биз. Би нэг хүн “Одоо тэрнийг ямар нүүр гаргахыг нь харах юмсан” гэж байхыг сонсож байлаа. Бас өөр нэг нь “Ха ха шившигтэй юм” гэнэ...

Маш олон хүмүүс намайг ч бас зүгээр байлгасангуй. “Гэнри тэр Ирэнэ Вилмэрын юунд нь болдог байнаа.” Паци Тиллинс гэгч алдартай сээтэн хүүхэн олон хүний санал бодлыг нэг өгүүлбэрээр хэлчихэж байсан юм. Харин одоо Хатагтай Хью— мания нийгмийн тэргүүн хүмүүсийн нэг (гэм нь хүнтэй гэрлүүлэх 3 охинтой) надад “Чи цагаа олж зугацан нь болсон юм. Угаасаа би тэр залууг нэг л бүтэхгүй амьтан гэж мэдээд байсан юмаа” гэж хэлж байна. Паци нүүрээ будангаа хажуугаас нь “Тэхээр хонгор минь дараагинх нь хэн бэ?” гэх нь дуулдана...

Эдгээрийн аль нь ч надад ямар ч нөлөө үзүүлэлгүй байж чадсан юм. Би ямар ч гэсэн нөхцөл байдалыг ойлгож, энэ свйрэл үнэхээр Гэнри-г дахиж босч ирэхгүй болгож уу үгүй юу гэдгийг мэдэхийг л хүсч байсан. Миний хүндэлдэг нэгэн бизнесмен санамсаргүйгээр миний бух асуултад хариулчихав. “Гэнри уг нь үнэнч шударга сайхан залуу байгаа юм” гэж тэр нэг найздаа яриж байсныг нь би санамсаргүй сонсчихсон юм. “Гэхдээ одоо аль болох хурдан өөрийгөө буудах л түүний нэр төрийг аварч чадах биз...”. Тэгээд л би бүхнийг ойлгов. Би удаан ч бодсонгүй, мөрөн дээрээ нэг юм авч хаячихаад л тэднийх рүү хамаг хурдаараа гүйж билээ. Түүнийгээ харсан даруйдаа би өөрийн эрхгүй айн чичэрсэн. Би түүнийгээ бараг л танисангүй: ширээн дээр сууж байгаа чулуун нүүр хөдөлгөөнгүй нүд түүнийх минь гэхэд итгэмээргүй байлаа. Сандалных нь хажуугаар түүний нэг гар нь амьгүй юм шиг унжиж хурууных нь өндөг нь үл мэдэг чичэрнэ.

Намайг орж ирэхийг ч тэр мэдсэнгүй. Би түүн рүү очоод толгойгоо өвдөгнийх нь завсар хийн сөхрөн унав. Тэр хэсэг дагжин байснаа гарыг минь хүчтэй татаж намайг босгоод “Гэртээ хари Ирэнэ.” Гэж хүйтэн утгагүй өнгөөр хэллээ. “Тэгээд дахиад хэзээ ч битгий эргэж ирээрэй!”

“Чи надад хайргүй юм гэж үү? Гэнри” гэж би өөрөө ч мэдэлгүй шивнэв.

“Одоо бидний хооронд юу ч болохоосоо өнгөрсөн гэдгийг чи ойлгохгүй байна гэж үү? ” гэж хэлэхэд түүний дуунаас нь; зовлон шаналал, уур уцаар ханхалж байсан. Би ойлгож байлаа. Гэхдээ би ойлгонгуутаа инээмсэглэсэн юм: энэ бүгд түүний хэлсэн үнэн байх ямар ч учир байхгүй. Мөнгө одоо бидний хайрыг сатааруулах гэж оролдож байна. “Мөнгө надаас Гэнри-г булаах гэнээ? Шог юм.” Би чанга гэгчээр инээж эхэллээ... Гэхдээ айдас дүүрэн инээдээр... Хэрвээ чиний бүхэл амьдрал, утга учир, чамд байгаа ганцхан бурханыг чин зөвхөн мөнгөгүй болсных нь төлөө орхи гавэл инээд чин хүрэхгүй гэж үү?

Тэр маань намайг сонсохыг хүсээгүй ч би сонсуулж чадсан юм. Хэр зэрэг удаан хэдэн цаг гуйснаа ч би мэдэхгүй байна. Тэр үгүйсгэсээр л байлаа. Тэр заримдаа зөөлхнөөр намайг орхихыг гуйж, заримдаа хүйтэн өнгөөр яв гэж хашгирч байв... Гэсэн ч би түүний нүдэнд нь байсан асар хүчтэй хайр хэвээрээ байсныг олж харсан. Тийм учраас явах тухай бодсон ч үгүй. Би түүний хөлд нь сууж “Гэнри Гэнри... Би чамгүйгээр амьдарч чадахгүй шүү дээ... чадахгүй” гээд уйльж байлаа. Гэхдээ л түүнийг намайг сонстол нь бас л зөндөө удсан... Гэхдээ цөхрөл ямагт залаа олдог юм билээ... Эцсийн эцэст тэр бууж өгсөн юм: тэр гэнэт намайг тэвэрч нүүрийг минь нулимс үнсэлт 200роо будаад “Тэгнээ... Ирэнэ.. тэгнэ” гэж хэлээд чичэрч билээ. Түүний их хайр нь бүдийг нь дуусашгүй их сэтгэл хөдлөлөөр дүүргэсэн байлаа.

Манай бяцхан хотынхны гайхширал Гэнригийн дампууралаар дууссангүй: тэд бид 2ын тухай дуулахдаа ёстой нэг дэлбэрэх шиг болж байлаа. Эхлээд түүнд хэн ч итгэсэнгүй. Итгэх ч аргагүй байсан юм чин... Тэд бүгд намайг галзуу солиотой мэтээр бодож байв... Гэхдээ үнэн би хайрандаа галзуурчихсан байсан юм... Хатагтай Хью хүртэл над дээр гүйж ирээд “Чи чин галзуураа юу? Чи түүнтэй гэрлэж болохгүй, Ирэнэ... Энэ чин тэнэг хэрэг... тэнэг...” гэж үнэн сэтгэлээсээ хэлж байсан. Тэр бүр хэлэх үгээ ч олохгүй байв. Түүний найз, өөрийгөө нэг их илэрхийлээд байдаагүй Ноён Броганхүртэл “Наадах чин солиорчихож” гэж хэлж байсан юм даг

Ноён Дэвис- манай эцэг эх 2ын хуучин анд надтай ярихаар ирлээ. Тэр намайг дахин энэ шийдвэрээ бодож үзэхийг хвсэв. Би өөрийнхөө ирээдүйг нөхрийнхөө өрийг төлөхдөө зарцуулах юм бол юу ч үгвй үлдэж хамраараа газар хатгана гэнэ. ха ха ха. Би үннийг сонсоод инээхээс өөр юу ч хэлсэнгүй. БИ дэндүү их жаргалтай байлаа.

Хамгийн холын хараатай үгийг Ноён Барнэс хэлсэн юм. Тэр над руу бодлогоширсон нүдээр удаан ширцэж амьдрал таньснийх нь ул мөр болж ульдсэн уйтгартай зөөлөн инээмсэглэлээр мишээж "Чамайг дандаа ийм их баяртай байхгүй л болов уу гэж би айж байна, Ирэнэ... Ийм их хвсэл мөрөөдөл, дэврүүн тэмүүлэл сайн юм авчирдаггүй юм шүү!" гэж хэлсэн юм. Дараагаар нь тэр ГЭнри руу эргэж "Стаффорд! чи өөрийнхөө алхах гишгэхийг мэдэж л яваарай даа..." гэж хүйтэн өнгөөр хэллээ. "Надад тэгж хэлэх тань илүүц биз дээ!" гэж Стаффорд түүнээс дутахгүй хүйтэн өнгөөр хариулсан юм.

Ингээд бид гэрлэлээ. ЗАрим хүүмүүс төгс аз жаргал хэзээ ч байдаггүй гэж хэлэх нь бий. Гэхдээ би тэр төгс аз жаргалыг амссан юм. МИний мэдэрч байсан тэр эмдрэмжийг аз жаргал гэхэд ч багадна... Би Гэнригийн эхнэр нь боллоо... Би одоо Ирэнэ Вилмэр биш Ирэнэ Стаффорд. Би гэрлэхихээд яг яжк байснаа санадаггүй юм. Ер нь юу ч санадаггүй юм. ХЭрвээ хэн нэг нь ирээд надаас гэрлэхихээд яж байсан ямар байсныг маань асуувал би ганцхан л үг хэлж чадна: "Гэнри". Тэр үргэлж тэнд байсан, надад өөр юу хэрэгтэй байх билээ дээ. Би өөртөө байсан бүхнийгээ зарж түүний өрийг дарж нэг ёсондоо түүнийг аварлаа. Бид одоо зөвхөн 2 биенийхээ төлөө амьдрах л үлдлээ: өөр хэн ч биднийг ядраахгүй, зөвхөн бид 2... 2 хvнь хамтдаа туулж болох хамгийн агуу амьдрал.

Гэхдээ нэг их удалгүй ирээдүйнхээ тухай бодохоос өөр аргагүй болсон юм. Бид нэгэнт надад байсан хамаг мөнгийг үрж, миний байшин сав, үнэт эдлэлийг бүгдийг нь зарчихсан байсан учраас, өөр орлогын эх үүсвэр олох шаардлагатай болов. ГЭнри их сургуулиа инженер мэргэжлээр төгссөн учраас энэ чиглэлээрээ ажиллах болов. ХЭдий нэг их

сүртэй ажил биш байсан ч урьд нь мэргэжлээрээ ажиллаж байгаагүй түүнд дажгүй л эхлэл байлаа.

Манайх гэдэг айл нэгэн бяцхан сууцанд амь зогоох болов. Тэгээд л амьдрал эхэлсэн дээ. Түүнийг зохих ёсоор ам;друулах гэж би өөртөө байдаг хамаг хүчээ шавхаж байв. Гэнри маань заримдаа эрч хүчээ хуваарьлаж чаддаггүй учир, БИ түүний ажилд нь ч хүтрэл туслаж байсан. Маш чухал ажлынхаа тэг дунд нь явж байж, буйдан дээр хэвтэж сонирхолтой ном уншин тамхи баагиулан хэвтэх нь түүний хувид байнга тохиолддог байв. Гэсэн ч би түүний ажлыг нь хийлгэх аргуудыг үргэлж олж чаддаг байсан бөгөөд тэр маань улам л илүү амжилттай ажилласаар байлаа.

Би түүний энгийн нэгэн найз нь юм уу зарц нь болж хувьрахгүйг хичээж байв. Би түүний эхнэр нь бас амраг нь байж чадсан гэж итгэдэг. Би өөртөө тодорхой бус жихүүн байдлыг бий болгосон нь намайг түүнээс үл мэдэг холдуулж, түүний сонирхолыг нь улам хөдөлгөж чаддаг байсан. Гэрийн бүх ажлыг чухам хэзээдээ хийгээд байгааг минь тэр хэзээ ч анзаарч байгаагүй. Би түүний хувьд баталгаат бараа биш гэрийнхээ хатан хаан, нэгэн нууцлаг оршин тогтногч болж чадаж байлаа. Бид 2 гэрийн амьдралыг хэзээ ч анзаарч байгаагүй гэж би итгэл дүүрэн хэлнэ. Бид асар хүчтэй сэтгэлээр жигүүрлэсэн амрагууд байлаа... Тэгээд л болоо...

Би түүний амьдралыг нь романс болгож чадсан. Би амьдралын өдөр хором бүрийг өөр өөр, сэтгэл хөдлөм болгож чадсан. ГЭр маань амарч, идэж унтдаг газар бус, тэр маань тэмцэж, хожиж, эзлэн авах тоглоомыг тоглодог сэтгэл хөдөлгөсөн ордон байлаа.

"Чам шиг бүсгүйг бүтээх гэж хэн бодож олдог байна аа, Ирэнэ." гэж тэр маань заримдаа хэлдэг байв. "Миний амьдарч байгаа нь зөвхөн чиний хүчээр юм шүү дээ" гэж хэлээд миний мөр хүзүүг маань гал халуун үнсэлтээр төөнөдөг байлаа. Би юу ч хэлсэнгүй. БИ ер нь түүнд хэзээ ч сэтгэлээ бүхлээр нь үзүүлж байгаагүй юм. Эр хүн өөрийгөө бүсгүй хүний

бvх амьдрал гэдгийг мэдээд хэрэггvй байдаг юм. ГЭхдээ л ГЭнри vvнийг мэдэрдэг байсныг нь би мэднэ.

Хэсэг хугацаа өнгөрсний дараа биднийг vл ойшоосон өнгөөр угцан хотынхон маань арай эелдэгээр хандаж эхлэв. Гэхдээ тэмцэл, хөдөлмөр, ганцаардалаас өөр зvйлгvй байсан эхний хэдэн жилvвдэд би ганцаарахнаа л; Гэнриг хөтөлж явсан юм. Тэр жилvвдэд тvvнд надаас өөр хэн ч хэрээгvй байсан гэдгийгээ би ам бардам хэлнэ. Манай гэрээр байнга ирдэг зогдын нэг нь миний сайн анд ноён Барнс бөгөөд тэр бидний амьдралыг анхааралтай ажиглаж, бидний vл бvтэх аз жаргалыг гайхдаг байв. Нэг удаа тэр "Ирэнэ, хэрвээ тэр чамд хайртай байхаа больчихвол ях вэ?" гэж асуусан юм. Би хамаг хvчээ гарган байж "ДАХиж наад тухайгаа битгий дурс, зарим юмнуудыг ярих ч хэрэггvй дэндvв муухай байдаг юм" гэж хэлж билээ. ТСАг хугацаа урссаар... гэвч бидний хайр хол хөндий болохын оронд улам бvр агуу болсоор байлаа. Бид одоо 2 биенийхээ харц, хөдөлгөөн, vйл хөдлөл бvхнийг уншиж чаддаг болсон байв. Тvvний ажлын өрөөний камин зуухны өмнө бид 2 vдшийг өнгөрөөх дуртайсан. Би дэрэн дээр сууж, хивсэн дээр хэвтэж байгаа тvvний толгойг өвдөг дээрээ тавиад дvрэлзэх галын элчинд удаан гэгч нь vнсэлцдэгсэн. "2 хvн яж ингэж нэг нэгтээ тохирдог байнаа гэж би хааяа боддог юмаа, Ирэнэ" гэж тэр заримдаа хэлнэ.

Бид ингэж 4 жил амьдарсан юм. Бvтэн 4 жил төгс аз жаргал, ухаангvй дурлал. Тийм их аз жаргал хvн болгоны амьдралд тохиолддог ч юм уу мэдэхгvй. Тэгээд бодохноо одоо би өөрийгөө зовж байна гэж хэлэх эрхтэй эсэхээ бас сайн мэддэггvй юмаа. Би амьдралд асар өндөр vнэ төлсөн нь vнэн ч, амьдрал надад бас агуу их аз жаргалыг бэлэглэж байсныг би мартдаггvй ээ! Миний туулж өнгөрсөн зовлон жаргал 2 ер нь л яг тэнцэх байх....

Бид 2 нийгмийн амьдралд дахин орж эхэллээ. хvмvвс бид 2ын жигтэй дурлалыг vзээд магадгvй ур;дынхаасаа илvвтэйгээр хvндэлж харьцдаг байсан байх. Гэнри-г хvн болгон л хvндэлж байдаг, хаа сайгvй урьж залдаг болов. Тvvний ажлын амжилт ч ахиж, ямартай ч хамгийн сайн инженерvвдийн тоонд зvй ёсоор багтдаг болсон байлаа. Тvvн шиг

хөгжилтэй сонирхолтой хvнийг зөвхөн мөнгө төгрөгvйгээс нь болоод нийгэм тvлхдэггvй юм билээ

Ийнхvв өөдөр хоног аз жаргалтай өнгөрч байтал тэр явдал болсон юм... Энэ бvхнийг би амьдарч туулсан юм чин бичэж чадах зориг надаас гарнаа...

Манай хотод нэгэн шинэ бvсгvй вэзэгдэх болов. Тvвний нэр нь Клэйр Ван Дален. Тэр нөхрөөсөө салсан Нью-Ёрк-д амьдардаг нэгэн байсан бөгөөд Еврөпе-с буцаж явахдаа манай хотод байдаг холын хамаатныдаа зочлохоор ирсэн байлаа. Би хамгийн анх удаа тvвнийг бvжгийн vдэшлэг дээр харж билээ. Тэр яг эртний уран баримал шиг уран гоо биетэй, алтан шаргал арьс гал улаан уруултай бvсгvй байж билээ. Хав хар vсээ голуур нь хувааж шулуухнаар самнасан бас урт ээмгийг эвтэйхэн нь аргагvй зvвсэн байлаа. Тvвний уян намуухан хөдөлгөөн нь биеийг нь ясгvй мэт харагдуулж, гар нь яг л урт тууз шиг намбалзан харагдж байв. Тэр маш энгийн хувцасласан боловч тэр л энгийн байдал нь мянган ногооноор ч vнэлэмгvй өвөрмөц байлаа... Тэр vнэхээр гайхалтай вэзэглэнтэй бvсгvй байсан юм. Манай хотынхон нөгөө бvсгvйн хөлд гайхал бахархалаа харамгvй шидэлцгээж байв. Аргагvй дээ, бид vнэхээр тvвн шиг бvсгvйг урьд хожид харж байсангvй. Тэр бvх хvмvвстэй эелдэг даруухнаар харьцаж байсан ч нvврэнд дээрхь хуурамч инээмсэглэл нь бусдын хайр хvндлэлд хэдийнээ дасч бvвр залхах болсныг нь бэлхэнээ харуулна.

ГЭнри тvвн рvв харав... удаан гэгч нь тогтууханаар... Урьд нь тvвнээс гарч байгаагvй тийм их бишрэл Клэйрийн хөдөлгөөн бvрийг ажиглах тvвний харцнаас нь тодхон байсан юм... Тэр 2 хэдэн удаа бvжиглэв.

Үдэшлэг төгсөхөд нилээд олон залуус тvvнийг гэрт нь хvргэж өгөхөөр яран сандралдан тvvн рvv очив. "За байз би сонгоноо" гэж Клэйр сэтгэл булаам инээмсэглэн хэлэхэд тvvний шинэ фенvүдйин нэг нь "Байгаа бvх хvнээс сонго" гэж хашхирав.

"Байгаа бvх хvнээс ээ?" гэж тэр давтан хэлээд жаахан бодолхийлснээ:

"Тэгвэл би Ноён Стаффордыг сонголоо." гэв. Хэдийгээр ГЭнри тvvнийг хvргэж өгий гэж хэлээгvй боловч тэр бяцхан гайхав. Гэхдээ ямар vгvй гэлтэй биш... Ноён Барнс намайг гэрт хvргэж ирэв.

Би Гэнри-г буцаж ирэхэд нь Клэйр-н тухай юу бодож байгааг нь асуулаа Тэр товч бөгөөд тодорхойгоор "Харин тийм. Сонирхолтой л юм" гэж хариулав. Би тvvнийг энэ хариултнаас хамаагvй илvvгээр сэтгэл нь хөдөлсөн байсныг харсан боловч нэг их юм бодсонгvй.

Дараагийн удаа бид vдэшлэгт уригдахад, Гэнри явах ямарч хvсэлгvй байлаа. Тэр ядарчихсан бас нилээд ажилтай байсан юм.

"Ээ, Гэнри яваы л даа. Биднийг хvлээж байгаа шvv дээ. Тэгээд ч тэнд олон хvмvүс байна Харвингс-нхан, Хатагтай Хью, хатагтай Брvүкс, Клэйр, Ноён Барнс гээд л" гэж намайг хэлэхэд тэр гэнэт бодлоо өөрчилж

"Ерөөсөө яв'я" гэв.

Тэр орой Клэйр Гэнри 2 хэнээс ч илvvтэгээр бvжиглэв. Клэйр нуруу нь ил гарсан даашинз өмссөн байсан бөгөөд би Гэнригийн гар тvvний торгон зөөлөн арьсанд уе уе хvрээд байгааг ажигалж байв. Гэнригийн нvд рvv ямар ч саадгvй ширтэх тэр хар сормууст нvд намайг гайхшруулж билээ. Ширээн дээр хvртэл тэр 2ыг нэг нэгэнд нь ойрхон суулгажээ. Үдэшлэгийг зохион байгуулагчид Клэйрийг баярлуулахийг хvссэн нь тэр байлаа.

Үvний дараагаар Гэнри Клэйр-н очсон нэг ч vдэшлэгийг алгасангvй. Тэр тvvнийг машинаар дагуулан явж, тvvний амьдардаг хамаатных руу нь хvртэл утасддаг байв. Хичнээн ажилтай байсан ч хамаагvй тэр Клэйр-н

театрт очих орой бvр тэнд очиж амждаг байлаа. Тvвний нvдэнд нь догдлолоор дvврсэн сонин харц байхыг би анзаарсан юм. харин тэр гэртээ байхдаа ухаан зулаггvй ажиллаж, хаашаа ч юм яараад байдаг байв.

Би бvгдийг алган дээрээ тавьсан юм шиг харж байв. Тэгээд vхтлээ гайхсанаас биш янзан бvрийн сэжиг төрж байсангvй. Үнэндээ тэр бодол миний толгойд яагаад ч орж ирэхгvй байлаа. Тэгээд л болоо. Тэгснээ Гэнри гэнэт л Клэйр-с хамаг холбоогоо таслав. Тэр гадагш гарахыг ч хvсэхээ байж , бvх урилгануудыг vгvйсгэдэг байв. тэр гэртээ бvрзийн суух болов... харин тэр бvрзгэр харанхуйн цаана юу байснийг би харж байлаа-- Айдас.

Тэгэхэд л би бvгдийг ойлгосон юм. Тvвний өөрийгөө татаж авах гэж оролдож байгаа нь надад vнэндээ ямар ч хамаагvй байлаа. Харин тvвний барьц алдаж байгаа байдал нь... Тэр байдал л надад бvгдийг ойлгуулсан юм. Гэхдээ мэдээж тэр дор нь биш л дээ. Иймэрхvв юмс хэзээ ч нэг дор болдоггvй... Хамгийн анх удаа надад сэжиг төрөхөд цус минь царцах шиг болж дотор муухай оргиж байлаа. Дараа нь эргэлзэл... Энэ эргэлзэлийг vгvй болгох гэж хичээсэн нь намайг улам л ихээр зовоосноос нэмэр болсонгvй. Үвний дараагаар тvвнийг анхааралтай ажиглаж эхлэсэн. Тэгээд л... Тэгээд л... Явдал учрийг яруу тодоор ойлгосон доо. Гэнри Клэйр-д хайртай болсон байлаа...

Тиймээ би өөрийнхөө хувь заяагvй 2 гараараа энэ өгvвлбэрийг бичэж байна. Хvний амьдралд ярихад ч хэцvв тийм зvйлс тийм ve гардаг юм билээ. Үвнийг би тэр вед л ойлгосон юм. Тэгэхэд би толгойдoo хамгийн анх удаа буурал вс олж харсан... Дараа нь галзуурал. Би vнэндээ vвнд итгэж чадахгvй байлаа. Би энэ явдалыг болоод байсныг харж байсан ч гэсэн энэ бугд миний толгой тархинд шингэж орж чадахгvй байлаа. Намайг эргэн тойрсон, над дотор байгаа тэр бvхэн эцэс төгсгөлгvйгээр, хэзээ дуусах нь мэдэгдэгхvйгээр унаж эхлэхийг мэдрэх ямар аймшигтай хэцvв байсан гээч... БИ эхэндээ асар тайван байлаа... Аймшигтай тайван. Гэхдээ тэссэнгvй би уйлж эхэллээ. ЗАрим шөнө аргаа барахдаа би гарнаасаа цус гартал нь хазчихаж байж билээ... Энэ бvгд тамын эцэст би

тэмцэхээр шийдсэн...

Миний толгой дах амьдралын дүр зураг тэр чигээрээ солигдож, хвйтэн харанхуй айдас намайг бүрхэн авав. Гэхдээ би хамаг болоод эцсийн хвчээ шавхан бослоо... би "Хүн авааль нөхрөө ингэж амархан явуулчихаж болохгвй" гэж өөртөө хэлсэн. Тэр нэгэн цагт минийх байсан юм чин дахиад минийх болохыг хэн байг гэхэв. Би түүний сэтгэл зүрхэнд нь яг юу болоод байгааг тодорхой харж байлаа. Эхлээд тэр Клэйр-тэй жаахан сээтэгнэсэн. Мэдээж тэр вед түүний хувьд ямар нэг ноцтой юм бодогдоогвй. Шинэ хүн түүнд сонирхолтой санагдалгвй яхав. Тэр хайр дурлалын тухай зүүдлээ ч үгвй байтал тэр нь аргагвй хврээд ирсэн. Үүнийг мэдсэн даруйдаа тэр энэ бүгдийг эцэслэхээр шийджээ.

Ингээд бид Зуулаа тэмцэж эхлэв. Би түүний төлөө, тэр өөрийнхө эсрэг. Бид Зуулаа удаан гэгч нь тэмцсэн ч... бид чадсангвй ээ! Тэмцэж байсан тэр ведээ тэр хэзээ ч надтай хвйтэн хөндий харьцаж намайг гомдоож байгаагвй. Тэр надтай үргэлжийнхээрээ зөөлөн намуухан харьцаж байв. Би ч баяр баясгалантай байсан бөгөөд... урьд урьдийнхаа улам илвй сайхан сэтгэл татам байх гэж оролдож байсан. Гэхдээ би түүнийг нэг ч хором буцааж, сэтгэлийг нь татаж чадаагвй юм даа. Бүх юм дууссан байлаа.

"ГЭнри, Зуулаа энэ үдэшлэг рүү явна аа!" гэж би нэг удаа их л шийдэмгий түүнд хэллээ. Бид 2 сүүлчин вед болсон бүх үдэхслэгний урилгануудыг буцааж байсан юм. Ингээд бид 2 тэр үдэшлэг рүү явлаа. Тэр Клэйр-г тэнд харав. Би ч түүнийг болгоомжтойгоор ажигав... Үдэшлэгний төгсгөлд бид 2 Зуулаа мэдэхийг хүсч байсан юмаа мэдэж авав. Одоо хичнээн ч тэмцээд нэмэргвй болжээ.

БИ тэр шөнө унцангвй. Би хичнээн хичээсэн ч хоолойг минь ямар нэг юм боочихоод болохгвй байлаа. "Бид 2ын хэн нэг нь энэ тамыг насан туршдаа эдлэх хэрэгтэй болжээ... Харин би юу? Гэнри юу?"... "Тэр зовох ёстой хүн нь би байх болноо... Гэнри л лав биш... Нэг л өдөр тэр надад

хамаг юмаа хэлнэ. Тэгээд л би салчихая. Хэрвээ тэр намайг явуулахгвй гэвэл би тэрэнд урьдынх шигээ их хайртай биш болсон гээд хэлнэ. Харин надад энэ бvгдийг хийх чадал хvч байгаа болов уу?" ... Ямар ч гэсэн тэр надтай аз жаргалтай байхаасаа өнгөрчээ...

Ингээд нэг орой тvvнтэй цуг галын хажууд сууж байгаад би өөрийгөө хvчлэн байж "Гэнри, хэрвээ би чамайг хайр;лахаа болисон гэвэл чи ях вэ?" гэж асуув. Тэр миний нvд рvв намуухнаар харснаа "Би итгэхгвй ээ!" гэсэн...

Цаг хугацаа явсаар байсан ч тэр надад vнэний тухай нэг ч vг цухуйлгахгвй байв. Би тvvнийг ойлгохгвй байв. Тэр магадгвй намайг өрөвдөж байсан биз, гэхдээ л эрт орой хэзээ нэгэн цагт надад хэлэх л ёстой доо. Тэр маань намуухан чимээгвй хэвээрээ байсан ч би тvvний арчаагаа алдаж цөхөрсөн нvд, цонхийж цайсан царайг харахдаа дотор минь муухай болдог байлаа. Ийм их сэтгэл хөдлөл эр хуньд ирэхээрээ хамаг ухаан санааг нь аваад явчихдаг юм. Би тvvнийг буруутгахгвй ээ! Тэр дотроо хичнээн их зовж байсан ч ганц ч vг дуугарсангвй. Зvрх зvссэн тэр өдрvвд намайг бас шууд зvгээр орхисонгвй. Тэр юу вэ гэхээр Гералд Греи Англи язгууртан залуу байлаа. 30 эргэм насны, дэгжин, сайухан хувцасладаг, ихэмсэг, эелдэг, сээтэгнэхээс өөр мэргэжил байхгвй тэр залуу манай хотод зочилж ирсэн байлаа. Манай хотын олон бvсгvйчvвд тvvнд дурласан байсан юмдаг. Харин тэр яагаад надад тэгж их татагдаад байсныг нь би мэдэхгвй ч тэр дургvйцлийг минь vl ойшоон над руу залгаж ярилцах гэж оролдсоор байлаа. Өглөө сэрэх бvртээ одоо л Гэнри-н vгийг дуулах болов уу гэж горьдсоор босч ирдэг байсан тэр өдрvвдэд надад тэр залуу бас л нэг ачаа болж байлаа.

Би Гэнри-г тэр тухайгаа ярьх болов уу гэж удан хvlээсэн. Гэвч тэр юу ч хэлсэнгвй. Клэйр Гэнри-тэй уулзах бvх нvх сvвийг хайж эрэлхийлж байсан боловч тэр Клэйр-тэй уулзаж болох бvх л боломжуудаас зайлшийж байлаа. Манайх гэдэг айл vдэшлэгний урилганд дарагддаг байсан. Эцэст нь Клэйр өөрийн гараа тусгай урилга Гэнри руу явуулсан байсан боловч Гэнри зөвшөөрөөгвй. Ингэж байтал нэгэн өдөр би бvхнийг ойлгосон юм. Тэр л өдөр би өөрийнхөө хувь заяаг шийдсэн...

БИ нэг үдэшлэг руу ганцаар явлаа. Мэдээжийн хэрэг Гэнри ажиллах ёстой гэж шалтаглан, муухай царайлаад гэртээ үлдсэн. Харин би үдэшлэгийг зохион байгуулж байсан дотно хүмүүсээ гомдоохгүйн тулд явахаар шийдсэн юм. Гэхдээ тэр үдэшлэг надад ёстой там шиг санагдаж байлаа. Явахад тохиромжтой цагийг хүлээн суух гэдэг тэвчээрийг минь шалгасан хэрэг байв. Гэхдээ тэр үдэшлэг рүү явсандаа би хэзээ ч харамсдаггүй...

Би өрөөг голуур нь хуваасан гоёмсог хөшигний хажуугаар өнгөрөхдөө Хатагтай Хью Хатагтай Броган 2ыг ярьж байхыг санамсаргүй сонсчихов. Тэд Гэнри, Клэйр, бас миний тухай ярьж байлаа.

- Ирэнэ түүний төлөө тийм ихийг төлсөн юм чин яхав дээ. Гэнри одоо түүнийг орхиж явж болохгүй шүү дээ гэж хатагтай Хью хэлж байна.

- Би ч гэсэн тэгж бодож байна. Ирэнэ чин үндсэндээ авааль нөхрөө худалдаж авсан юм шүү дээ. Гэнри одоо үхэх гэж байсан ч түүнийгээ үзүүлэх эрх түүнд байхгүй шд гэж хатагтай Броган хатагтай Хью-г дэмжих нь тэр... Би барьж байсан алчуураараа амаа таглав... Би одоо л учрыг ойлголоо... Би ганцаараа гэр лүүгээ алхав... Би нөхрөө худалдаж авсан... Авааль нөхрөө эд бараа шигээр худалдаж авчээ, би. Үүнд л хамаг учир нь байж. Тэр одоо намайг орхиж явж ч чадахгүй.. надад энэ тухай хэзээ ч ам нээхгүй... Тэр зовлонгоо өөртөө л хадгалах болно... Тэр надтай жаргалтай байхаасаа нэгэнт өнгөрсөн ч гэсэн насан туршдаа юу ч болоогүй юм шиг явах болно... Миний мөнгөнөөс болж... Хэрвээ тэр ярайхгүй юм бол би ярих учиртай...

Хэрвээ тэр мөнгө миний амьдралд байхгүй байсан бол би үүнийг хийхгүй байсан биз. Магдагүй би үргэлжлүүлэн тэмцэж Гэнригээ буцааж авах байсан байх. Гэхдээ одоо бүгдийг мэдсэн хойно- би чадахгүй ээ! Надад тэгэх зүрх байсангүй. Тэр хэзээ нэгэн цаг наддаа сэтгэлээрээ буцаж ирсэн ч гэсэн би түүнийг надад хайртайдаа буцсан уу эсвэл миний өөрийнх нь төлөө золиосолсон бүхэнд талархан буцсан уу гэдгийг яж мэдэх билээ дээ... Тэр миний мөнгөний аолиос нь болж байгаа эсэхийг би хэзээ ч мэдэхгүй болжээ...

Би тvvнийг сайн дураараа чөлөөлөх ёстой... яагаад гэвэл тэр надад дэндvv их өртэй учраас... Би тvvний төлөө хэтэрхий ихийг золиослох чадалтай байсан учраас би нөхрийгөө хадгалж явах эрхгvй болсон байлаа.

Би ямар ч гэсэн хо;длох хэрэгтэй. Яах вэ? САлая гэх vv? Тэр мэдээж хвлээж авахгvй... Тvvнд хайргvй гэж хэлэх vv? бvvр vнэмшихгvй...

МАлгайгаа толгой дээрээ байлгаж тэсэхээ болиод авахад бяцхан бороон дуслууд духан дээр минь vнсэж, зөөлөн салхи vсийг минь илбэж байлаа... Би шийдэв... Ямар ч гэсэн зvрхэн дээрээс нэг юмыг аваад хаячих шиг болов.

Байшиндаа дөхөж очоод харвал Гэнри-гийн ажлын өрөөний гэрэл асаалттай харагдав. Би тvvнд садаа болохгvйн тулд чимээгvйхэн гэртээ орж, тvvний өрөөнөө хажуугаар өнгөрөхдөө зvрхийг минь зvссэн тэр нэгэн дууг сонсов... Чихэндээ итгээгvй би гэдэг хvн өрөөнийх нь хаалгаар харлаа... Гэнри ширээн дээрээ сууж толгиогоо базлан уйлж байлаа. Над руу харсан байсан нуруу нь гvн харуусалаар дvvрэн нулимсыг нь гvйцээж чичрэн байв. Би хаалганаас ухашийн холдохдоо ухаан санаагаа алдчихсан мэт болсон байлаа. .. Гэнри уйлжээ...

"... Гэнри одоо vxэх гэж байсан ч тvvнийгээ vзvvлэх эрх одоо тvvнд байхгvй шд..."

Би өөрийнхөө юу хийх ёстойг сайн мэдэж байлаа. Тэр намайг өөрт нь хайргvй болсонд vнэмшигvй тэхээр би тvvнд ямар нэгэн аргаар vнэмшvvлэх л хэрэгтэй.

Би өрөө рvvгээ айдас хvйдэс, цөхрөл гунигаа дааж ядан орлоо. Өглөө нь харин сэрэхэд сэтгэл нэг л тайван... Тэр шөнө юуны тухай бодож хоносноо би энэ хорвоо дээр нэг ч амьд хvнд ярихгvй.

"Ирэнэ, Юу болоо вэ?" гэж Гэнри өглөө нvд рvv минь харангаа асуув.

"Юу ч болоогүй ээ!" гэж би хариуллаа. "Онцгүй зүүд зүүдлээд... гэхдээ одоо дуусчихсан учраас санаа зоволтгүй" гэж би хэллээ. МИний тэр үед бодож чадах ганцхан зүйл гэвэл би Гэнри-д өөрийнхөө худал хурмаг гэдгийг үзүүлэх боломж олох тухай л байв. Түүнийг ямар ч эргэлзээгүй болгох хэрэгтэй... Тэр боломж яг тэр өдөр хүрч ирсэн юм...

Гадуур явж биагаад гэртээ буцаж ирэхдээ, Гэнри-гийн ажлын өрөөнөөс Клэйрийн дууг сонсов. Би гайхсангүй. Би хаалганд дөхөж очин түлхүүрний нүхээр нь тэднийг харж юу ярихыг нь тайвнаар сонсов. Сайхан шаргал хослол дээр тод ногоон алчуур тавьсан Клэйр-г би харсаан. Тэр үнэхээр дэнүү үзэсгэлэнтэй харагдаж байлаа.

Гэнри "Дахиад нэг удаа хэлье. Хатагтай Клэйр та манай гэрээс гарна уу! Би таныг харах ямар ч хүсэл алга. Та ойлгохгүй байна гэж үү?" гэх нь дуулдана.

"Үгүй би ойлгохгүй байна" гэж Клэйр чангаар хэлэв. Тэгснээ Гэнри рүү хөөрхөн нүдээ жижигхэн болгон хараад "Чи муу хулчгар новш" гэж удаахнаар хэллээ.

Гэнри Клэйрийг ширтэн хэсэг зогссоноо түүн рүү нэг алхам ойртов. Түүний цайж цонхийсон нүүрнээс нь ялгаран харагдах уруул нь хаалганы нүхээр харж буй надад хүртэл харагдахаар чичэрч байлаа.

"Яв даа!" гэж тэр хачин хахирган дуугаар шивнэв. Тэгэхэд нь Клэйр нүдээ том болгон бүрэн нээхэд, түүний өөрөөсөө хүртэл нуух гэж ядсан хүслэн, омог бас асар эмзэг сэтгэл нь харагдаж байлаа.

"Гэнри..." гэж хэлэхэд түүний хоолой нь ягаад ч юм бие шигээ үзэсгэлэнтэй сонсогдоно.

"Хатагтай Клэйр..." гэж Гэнри арай ядан хэлээд хойш ухрав.

Клэйр түүн рүү дөхөнгөө "Гэнри... Чи ингэж 2 биенээ зовоох ямар хэрэг байгаа юм бэ?... Би чамд хайртай... Чамтай л байхыг хүсч байна" гэж хэлж байна. Гэнри үг ч дуугарах сөхөөгүй байхыг харсан Клэйр дуугаа өндөрсгөн муухан инээмсэглэж "Чи надад хайртай гэдгийг бид 2 Зуулаа сайнаас сайн мэдэж байгаа шдээ. Чи арай үгүй гэхгүй биз дээ?" гэж хэлэв.

Гэнригийн нүдэнд зовлон тарчлал илээс ил харагдаж байхыг нь би удаан харж тэсэмгвй байлаа. тэр ч үүнийгээ мэдээд нүдээ гараараа таглав.

"Чи энд ях гэж ирсэн юм бэ???"

"Ягаад гэвэл би чамд хайртай... чамтай хамт байхыг юунаас ч илүү хүсч байна." гэж Клэйр хэлээд Гэнригийн мөрөн дээр нь гараа тавьж "Надад чи харитай биз дээ" гэж шивнэн асуув.

"Тиймээ... тийм... тиймэээ!" гэж Гэнри чангаар хэлээд Клэйрийг галзуурсан мэт татан ойртуулж уруул дээр нь озон озон үнслээ. Би гайхсангвй. Надад бүх юм урьд нь болж байсан уым шиг л санагдав. Харин Гэнрийг өөр бүсгвй үнсэхийг харах... хэцүү байсан учраас би нүдээ аньсан... Тэгээд л болоо...

"Ингэж хэлэхийг чин ямар их хүлээв ээ, би!" гэж Клэйр эцэст нь хэлээ Гэнрийг чангаар тэврэв. Магадгвй хүсч байснаасаа ч чангаар тэвэрсэн байх. гэтэл Гэнри гэнэт Клэйрийг шийдэмгийгээр түлхээд...

"Чи бид 2 дахиж уулзаж болохгвй..." гэж хатуухан өнгөөр хэлэв.

"Үгвй дээ... хонгор минь чи бид 2 өнөө орой уулзана...Орой 9 цагт би чамайг Холтос-т хүлээж байя."

"Би ирэхгвй ээ!"

"Чи мэдээж ирнэ."

"яасан ч үгвй... хэзээ ч..."

"Чамаас гуйж байна шдээ Гэнри... 9 цагт!" гэж Клэйр хэлээд өрөөнөөс гарч явлаа. Би дөнгөж л хөшигний ардуур орж амжив. Клэйрийг явсаны дараа би Гэнригийн өрөө рүү шагайвал Гэнри сандал дээрээ толгойгоо базлан сул ойчсон байдалтай харагдана. Үсээ зогсоо зайгвй зулгаан байгаа хуруунуудаас нь би Гэнри-г хичнээн их зовж байгааг харж байлаа...

Ингээд надад боломж гарч ирлээ... Одоо л хөдлөх хэрэгтэй...

Би өрөөндөө очиж малгай,цуваа тайвнаар тайлав. Би өрөөнөөсөө гарч шатаар уруудан Гэнри рvv явах гэж байснаа гэнэт зогтусав. "Чи мэдэж байна уу?хэнийг алдах гэж байгаагаа мэдэж байна уу, Ирэнэ?" гэж би өөртөө хэлээд гvн амьсгаа авлаа...

Ширээн дээр минь Гэнригийн нэг зураг байдаг байсан юм... Тvvний хамгийн сайхан гарсан зураг... Харин ард талд нь "Хайрт Ирэнэ-дээ. Гэнри. Үүрд мөнх" гэж бичсэн байдаг байлаа. Би зурганд хүрч очоод, газар өвдөглөн сууж тvvнийхээ зургийг удаан гэгч нь ширтэж залбирсан. Тvvндээ мөргөсөн..."Гэнри... Гэнри..." гэж би шивнэхээс өөрийг хэлэх чадал надад vнэндээ байсангvй. Надад төлөвлөсөн бvхнийг хийх хvч чадал хайрлаач гэж би тvvнээс гуйж билээ.

Хэсэг хугацааны дараа би босч доод давхар луу явав.

"Гэнри. Надад Хатагтай Кован захиа хүргvvлсэн байна. Өвдсөн гэнээ. Би оччихоод ирээ." гэж тvvний өрөөнд орж хэлчихээд гарлаа. Хатагтай Кован гэдэг нь миний бvvр дээрний нэг танил, манай хотоос 4 цагийн зайд амьдардаг бvсгvй. Би хааяахан очиж хуучилдаг байсан юм.

"Би чамайг явуулмааргvй байна. Чи бvvр цонхийгоод ядарчихаж... амрах хэрэгтэй" гэж Гэнри ер юу ч болоогvй юм шиг духан дээр минь гараа зөөлхөн тавиж хэлэв.

"МИний бие маш сайн байна. Би явчихаад маргааш өглөө хүрээд ирнэ."

Би өрөөндөө утастай байсан учраас Гэнри миний ярихыг сонсож чадахгvй байх байв. Долоон цагийн вед би Гералд Грэй руу залгаж товч бөгөөд тодорхойгоор "Та 8.30д Холтосд хүрээд ирэхгvй юу?" гэж хэлсэн юм.

"Ю... Юу гэнээ? Ох, Хатагтай Стаффорд!" гэж гэнэтийн бэлэгт баярласан тэрээр барьц алдан сандран хэлж байна. Би ч олон долоон юм ярьсангvй уцаа тавилаа... МИний төлөвлөгөө махс хялбар. гэнри 9 цагт Холтос-д Клэйр-тэй уулзахааар ирнэ. Тэгээд Грэй бид 2ыг харна. Би шөнөжөнгөө байхгvй байна гэж хэлсэн болохоор тэр хараад уурлана. Тэгээд л тэр.

Би тайвнаар хувцаслаж эхлэв. Би маш нямбай сайхан хувцаслахыг бодож хамаг тавгвй бодлоо гээхийг хвсч байлаа. Гялалзсан жижигхэн хиймэл чулуунуудтай, мөнгөлөг өнгөтэй даавуун даашинзаа өмсөж, нvvрээ будав. Би хөөрхөн харагдахыг хвч байлаа: гэхдээ тэгэхийн тулд маш их будаг шунх хэрэглэх хэрэг гарч билээ. Ингээд сууж байтал гэнэт толгойд минь "хэрвээ Гэнри Холтос-д ирэхгвй бол яах вэ? Тэр "Яасан ч vгвй гэж их л шийдэмгий хэлсэн шvv дээ. Тэр Клэйр-г эсэргvнцэж дөнгөх тийм их сэтгэлийн тэнхээтэй байвал яхав..." гэсэн бодол зуршийн орж ирэв.

Энэхvv гэгээн бодолд цочсондоо би гартаа бариж байсан энгэсэгний шаазан хайрцагаа газар алдаад хагалчихав. "Хэрвээ.. хэрвээ тэр ирэхгвй бол, тэр Клэйр-т тийм ч их хайртай биш гэсэн vг. Тэгвэл би гэр лvvгээ хамаг эрчээрээ гvйж ирээд тvvнйигээ тэврэн хамаг vнэнээ уйлан байж хэлнэ дээ." Ингэж бодоход өчигдөрөөс хойш хуурай байсан нvд маань том том дуслуудаар дvvрч зарим нь хацар даган урсав. Гайхалтай хэрэг шvv... Хvн итгэлээ алдаж, цөхрөнгөө барсан уед итгэл найдвар өчvvхэн төдий сvvмэлзэхэд сэтгэл хамгийн хэцvvгээр зовдог юм билээ.

Би тайван байхыг хичээж хувцасаа өмсөж эхлэв. гар минь учиргвй чичирч байсан учраас хувцасаа өмсөх гэдэг амаргвй даваа байлаа. хувцаслаж дуусчихаад аялалын том цуваа нөмөрч vдшийнхээ даашинзыг нуув. Гарч явахад минь Гэнри өрөөнөөсөө гарч ирэн цувны маань захыг чанга гэгч нь товчилж өгөөд, "Анхаарлтай яваарай! Битгий хамаагвй ядарчихаарай, Ирэнэ минь" гэж хэлж билээ.

"Санаа зоволтгвй Гэнри. Би зvгээр..." гээд би тvvнйигээ vнссэн. хамгийн сvvлчийн удаа...

Ингээд л би гарч явсан... Харанхуй гудамжаар ганцаараа алхаж явахад хvйтэн салхи цувны минь доогуур гулгаж нvцгэн мөрөнд минь хурч байсаан... Зөөлхөн даавуу хөлийг маань илбэхэд би толгой дээгvvр,эгц алхах гэж байдгаараа хичээж байсан юм.

Холтос гэдэг нь манай хотын хамгийн том шөнийн клуб байлаа. Нэг их муу нэрттэй газар биш байсан ч гэсэн яагаад ч юм хvvхvvд нэг бол нөхөртэйгээ ирдэг эсвэл бvvр ирдэггvй байсан юм...

Би ХОЛТОС хэмээх нэрийг бvтээсэн том том гэрэлт всэгнvvдйиг харав. Хэтэрхий их гэрэл нь бараг л нvд өвтгөмөөр санагдаж байж билээ. Үvдээр нь орж дээд давхарт гарав. Зөөлөн хивсэнцэр дээр нь хvн өөрөө өөрийнхөө хөлийн чимээг сонсох ч янзгvй. Хэтэрхи гял цал болсон уйлчлэгчдийнх нь гялгар хувцаснууд нь алмаз эрдэнэ шиг хуурамчаар гялалзана. Төв танхимд нь орж ирэв vv vгvй юу жазз хөгжимийн хурц аялгуу толгой дотор минь шургаад орчих шиг л болов. Том том гэрэл vvсгvvрvvд... цагаан ширээнvvд... хар костюм... нvцгэн мөр... гялалзсан шил... торгон хэрэглэл... алмаз чулуу...

Ноён Грэй намайг хвлээж байлаа. Тэр яг л дээд зэргэлэлийн эрэгтэйчvvдйин сэтгvvл дээр гардаг гял цал зураг шиг өнгөлөг харагдаж байв. Мэдээж хvнтэй харьцаж сурсан эр гэсэндээ сэтгэл хөдлөл юм уу гайхсан ямар ч хсинж тэмдэг узуулсэнгvй, эелдэг бөгөөд хvндэтгэлтэйгээр инээмсэглэсээр. Би ширээ сонгохдоо vvдээр орж гарч байгаа хvmvvсийг харж болох газрыг бодолцож сонгов. Ширээн дээр очоод vvд ширтэж суухад бvх юмсыг будэгхэн vлэн хөшиг бvрхсэн мэт санагдаж байсан юм. Бvх юмс манаран тунарч байхад ганцхан цэнгээний газрын хаалга л томруулдаг шилээр харж байгаа мэт тодоос тод харагдана. Одоо хvртэл.

Миний санаж байгаагаар Ноён грэй нэг юмны тухай л яриад байсан. Би бас ярьсан. Тэр инээмсэглээд л. Би бас инээмсэглэсэн байх. Хаалганы яг дээд талд нь том цаг байсан юм. Намайг Холтос-д хvрч ирэхэд цаг 8.30 болж байсан. Би тэр цагийг ширтэж цаг аажуухнаар явсаар байсан. Хэрвээ яг тэр вед хэн нэг нь миний сэтгэл рvv өнгийсөн бол том цагаан дугираг 2 зvvнээс өөр юг ч олж харахгvй байсан байх даа.

Яг 9 цагт, хормыг заагч зvv 12 тоог шvргэв vv vгvй юу том шилэн хаалга онгойв. Яг л миний хвлээж байснаар. Гэхдээ орж ирсэн хvн нь Гэнри биш Клэйр байлаа. Тэр ганцаараа орж ирэв. Цул хар өнгөтэй сатин даашинз нь тvvний биеийг зөөлнөөр ороожээ... толгой дээрээ тавьсан гоёмсог

алмазан зvvлт нь гялалзаж, сайхан мөрөн дээгvүр нь гялалзах чулуунууд гvйх нь дуу алдмаар vзэсгэлэнтэй... Клэйр орж ирмэгцээ тээнгэлзэж танхимыг тэр чигт нь гvйлгэн харав. Гэнриг ирээгvйг мэдмэгцээ уруул нь уураа дааж ядсан бололтой чичэрч байна. Гэвч яая гэхэв тэр танхимыг туулаад нэг ширээнд очиж суув. Тvvний суусан ширээ нь миний байрлалаас сайн харагдаж байлаа.

9.15... Том шилан хаалга онгойх нь улам л олширч костюмтай залуус эрчvүд, vслэг эдлэл даашинз болсон хvүхнvүд чимээгvйхэн орж ирж шуугилдах олонтой нийлж байв. Би хаалганы өмнө дэвссэн зөөлөн хивсэн дээгvүр эцэсгvй мэт урсах ширэн гутал, мөнгөлөг шаахайнуудын урсгалыг ширтэж суулаа. Ядаж байхад ямар олон хvн орж гарсан гэж бодноо тэр хаалгаар. Хаалга нээгдэхийг сонсох бүрт минь хvйтэн айдас нуруу руу минь шургаж өвдөг рvү маань урсаж байлаа. Гэвч би хаалга руу харалгvй нэг ч хором сууж чадаагvй юм. "Болгоомжтой, Хатагтай Стаффорд" гэж Грэйнд хэл;эх нь зvүд зэрэглээ шиг хол сонсогдов. Учир нь би барьж байсан усаа даашинз руугаа асгачихаж. Би гэхдээ тоосон ч vгvй аяган дах мөснөөс нэгийг авч ам руугаа хийлээ. Грэй над руу гайхал дvүрсэн нvдээр харж байсан юм.

9.25. Өвдөг маань гэм хийсэн хvнийх шиг чичирч байв. Хэтэрхий их чичэрснээс болоод дахиж хэзээ ч алхаж чадахгvй болчихмоор юм шиг санагдаж байж билээ, тэр вед. Би нууцхан Клэйр рvү харав. тэр бас л хвлээсээр байлаа. Тvvний нvд нь бас л хаалган дээр хадаастай. Ширээн дээр байсан цэцгийн дэлбээг тасдан хаях нь тvvнийг хичнээн их санаа зовж байгааг харуулж байлаа.

9.30. Би тэвдэж байсандаа тэр юм уу, эсвэл тэнд байсан жазз хөгжим тэгж хvнд дуулдаж байсан уу толгой руу маань хvнд зvйлээр зогсоо зайгvй нvдэж байгаа юм шиг санагдаж байв. Бvгчимдэж, бачимдсан сэтгэл минь агаар муу танхимын аяыг даалгvй боочихмоор санагдаж би хvйтэн гараараа хоолойгоо барьж суулаа.

9.45-д тэр ирсэн юм. Хаалга нээгдэж, тэр орж ирэв. Яг л тэр хоромд Гэнри агаарт өлгөгдчихсөн юм шиг санагдаж байлаа. эргэн тойронд юу ч

байхгвй юм шиг... Би хаалгыг харж байсан боловч яг урд нь зогсож байгаа Гэнриг л харж чадахгвй байлаа. Тэр харанхуй нvх мэт надэд харагдаж байв. Дараагийн хоромд нь би юуг ч сонсоогвй юм. Чих минь таг дvлий болсон мэт чив чимээгвй намайг нэг хором бvрхэв.

Энэ мөчид би арай гэж сэхээ аван Грэй-д "жаахан хөгжилдөө л дөө" гэж хэлэв. Би тvнний хvзvvгээр нь тэвэрч, мөрөнд нь нvврээ наагаад костюмных нь захыг чангаар хазав. Тэр вед би ганц л юм өөртөө хэлж байсан нь "ирэнэ хэтэрхий чанга хашхирч болохгвй"...

Грэй хаалга руу биш над руу харж сууж байсан болохоор Гэнри-г орж ирэхэйг харсангвй, учрыг ч ойлгосонгвй гайхаж дууссан бvдээр над руу харж суув. Гэхдээ жинхэнэ эр хvний зангаар тэр өөртөө итгэлтэй загнаж всэнд маань гараа хvргэхийг хvртэл оролдож байлаа.

Би толгойгоо тvн рvв харж байсан ч нvврэндээ ямар ч хувирал гаргахгвйг хичээж байсан юм. Гэхдээ нvд маань бvхнээ нууж дөнгөсөнгвй бололтой... Грэй миний нvд рvв хараад бараг л дуу алдах дөхөж байгаа нь илт. Би салга хvн шиг гартаа барьсан жунзаа счичрvвлэн байж "Грэй, дарс хаана байнаа. Би дарс уумаар байна. яагаад энд дарс байхгвй байгаа юм" гэж хашгичив. Намайг уурлуулаад дэмийг ойлгосон Грэй вйлчлэгчийг дуудаж чихэнд нь нэг зvйл шивнэхэд вйлчлэгч инээмсэглэхихээд яваад өглөө.

Би энэ бvхний хажуугаар Гэнри ажигласаар байлаа. тэр Клэйр дээр хvрч очив. Клэйр хэтэрхий их баяраар дvврч байгаа бололтой сандал дээрээсээ всрэн бууж жаргалтайгаар инээмсэглэсэн. Тэр Гэнри-г ирэхгвй нь гэж сандарч байсан бололтой тvннийг хоцорсон тухай нэг ч vг хэлсэнгвй. Харин Гэнри цонхийж цайсан ноцтой царайгаа нууж чадалгвй зогсоно. Тэр хоцорсон нь надад бvгдийг урьдынхаас ч тодоор хэлж өгч байлаа. Гэнри ирэхгвй байх гэж их тэмцжээ... Үнэхээр их... Гэвч тэр тэссэнгвй юм байж... Гэнри Клэйрийн ширээнд очиж суув. Тvнний нvдэнд унтрашгвй их баярын оч гялалзаж, инээмсэглэнэ... Ямар вээсгэлэнтэй сайхан харагдаж байснаа тэр хэзээ ч мэдэхгвй ээ...

Зөөгч надад дарс авчирч өгөв. Бvүр 2 шилийг. Грэй нэг шилийг нь авч шилэн аяганд цутгах гэсэн боловч би Гэнригийн гараас дарсыг нь булаан авч өмнөө байсан шилэн аяганд хийхдээ цvл пал хийлгэн асгаж даашинзан дээрээ хvртэл цутгачихав. Тэгээд нугуу дуурэн аягаа авч газар унагалаа. Шил хагарах чанга дуутай нийлvүлэн би чангаар инээж эхэллээ.

Грэй бvүр амаа ангайчихсан зогсож харагдана. "Инээ, чангаар хөхрөн инээ" гэж би Грэйд тулган хэлэв. Бидний ойр сууж байсан хvмvүс хэн тэр бvдvүлэг дуу гаргаад байгааг сонирхон эргэн эргэн харсаар байлаа. Яг л миний хvссэнээр.

Би усээ задлан сэгсийлгэж, бvүр сvүлдээ шилтэй дарсыг газар чулуудлаа. Хамаг чангаараа инээж "Ох Гэри минь" гэснээ энэ маань хангалттай санагдсангvй сандалаасаа босч Грэй-н өвөр дээр нь сууж тэврэн vнсэж буй мэтээр нvүрээ нvүрэн дээр нь наалаа. Ингэхдээ нь хажуудаа байсан хиймэл ханыг тvлхэн унагав. Бvхэл танхим тэр чигээрээ эргэн харахад би ичиж буй царай гарган босох тэр агшинд Гэнритэй нvүр туллаа. Би над руу харж байсан тvүний нvдийг хэзээ ч мартагvй... Бид 2 чимээгvй байлаа. "Ирэнэ... Ирэнэ" гэж тэр итгэж ядан шивнэж байв.

Би айж ичиж байгаа хvний дvрийг гаргах гэж хичээж байснаа толгойгоо өргөн огт тоогоогvй царай гаргаж "Тэгээд?" гэж хэллээ. Гэнри хойшоо ухрав. Тэгээд чичирсэн. Тэр нvдэндээ итгэхгvй байгаа бололтой хэсэг дарж байснаа "Би чамд саад болохгvй ээ!" гэж хэлээд Клэйр рvү яваад өгөв. "Өөр газар луу явая Клэйр" гэж тэр Клэйр-т хэлж байна. Клэйр ч босч тэр 2 гараад явчихав. Би тэр 2ыг шилэн хаалгаар харагдахгvй болтол нь дагуулан харж билээ... Тэгээд л бvх юм дууссан...

Би тэднийг явсны дараа асар тайван болж билээ. Би Грэй руу эргэхэд тэр миний унагасан хиймэл ханыг босгож тавьж байлаа. Тэгээд "Хатагтай Стаффорд, битгий өөрийгөө зэмлэ дээ. Энэ ч дээр байсан биз." гэж хэлсэн.

"Тийм ээ, Грэй, ингэсэн нь ч дээр байсан юм" гэж би чимээгвйхэн хэлсэн.

Бид 2 буцаж ширээндээ суун, чимээгвйхнээр хоолоо идэж дуусгалаа. МИний бvх ухаан санаа тогтуун тайван байлаа. Би инээмсэглэн ярьж хажуугаар нь зөөлхөн сээтэгнэж байсан тул Грэй нөгөө ичгэвтэр явдалын тухай нэг их санаа зовж байгаа янзгвй сууна. 10.30-ын вед би тvvнийг гэрт маань хvргэж өгөхийг хvслээ. Тэр ингэж тvргэн салах болсондоо сэтгэл дундуур байгаа нь илт боловч юм хэлсэнгвй эелдэгээр машиндаа суулган намайг гэрт маань хvргэж ирлээ. "Зуулаа удахгвй дахиж уулзана биз дээ?" гэж гэрийн vүдэнд ирчихээд гарыг маань атган байж асуув. "Тэгэлгвй яхав. Тун удахгвй... ойр ойхон уулзах болно." гэж намайг хариулахаад Грэй баяр хөөрөөр дуурч яваад өгөв.

... Би гэртээ орж ирлээ. Хичнээн ч удсан юм бvv мэд ямар ч гэсэн би хөдлөлгвй удаан зогсов... Бvх юм нэгэнт ард хоцорчээ.

Би Гэнри-н ажлын өрөөнд нь орлоо. Газар хэвтэх хэдэн цаасыг авч ширээн дээр , өрөөний голд тавьсан сандалыг байранд нь тавив. Буйдан дээрхи дэрнvvдийг засч дараа нь Гэнри-н ширээн дээрхь зураг тосол гэх мэт зvйлсийг янзлав. Тvvнийг шугам, гортиг, бусад хэрэглэл нь газраар нэг тарж. Би тэр бvгдийг нь ширээн дээр нь тавиад зууханд гал асаалаа. ингэж хамгийн сvvлчийн удаа гэртээ эхнэр шиг байлаа би.

Бvх юмийг янзалж дуусаад. би галын дэргэд очиж газар суув. Зуухны хажууд байдаг Гэнри-н тvшлэгтэй сандал , хөлөө тавидаг дэрийг нь баахан харж суулаа. САндал дээр нь сууж зvрхлээгвй учраас, хөлнийх нь дэрэн дээр толгойгоо тавиж харанхуйг бvдэг улаан гэрлээрээ, чимээгвйг дуугаараа vргээх галыг ширтэн хэвтэв. Байн байн тэр дэрийг vнсэж байснаа би санаж байна....

Yүдний өрөөнд тvlхvvp шажигнах дуу гарахад би хурдхан босч, vүдний өрөө рvv очив. Гэнри цонхийчхоод зогсож байна. Над руу харсан ч vгвй, хувцасаа тайлж өлгvvрт өлгөөд хажуугаар минь зөрөн ажлынхаа өрөө руу явлаа. Би ч дагалаа.

Бид өрөөнд орсны дараагаар чимээгвйхэн удаан зогссоны эцэст тэр хvйтэн хөшvvнээр:

"Чи надад ямар нэг юм тайлбарлах у?"

"Надад тайлбарлаад байх юм байхгвй ээ! Чи бvгдийг нь харсан."

"Тиймээ би харсан..."

Тэр өрөөг өгсөж уруудаж хэсэг байснаа над руу харан vзэн ядалт, гутамшиг дvврэн инээмсэглэлээр инээмсэглээд "Гэхдээ энэ чин сайн хэрэг!" гэж хэлэв. Намайг юу ч хэлэхгвй байгаад тэр улам улангасч "Чи... чи... яж ингэж чадаваа" гэж хамаг чангаараа хашгирав. Би чимээгьи л байв.

"Чам шиг эмийг би 4 жилийн турш эхнэрээ гэж дууджээ. Чи намайг бvвр галзууруулах нь Ийм юм байж хэрхэвч болохгвй. Энэ бол чи биш. Чи ийм байгаагүй шvв дээ. Чи ийм юм хийж чадахгвй." Би юу ч хэлсэнгвй.

тэр гараас минь зууран авч намайг газар луу тvлхээд "Чи новш минь. Яриач. Хэлээч! Хариулаадах надад. Ягаад чи ингэж байгаа юм бэ?"

Би тvвнийг нvд рvв нь харж байгаад хамгийн гашуун худлыг тvвндээ хэллээ. "Би чамайг гомдоохыг vнэхээр хvсээгвй учраас энэ хайраа удаан нууж явсан. Би удаан хичээсэн бовоч vнэхээр тэсч чадаагвй." гэж би хэлсэн. Тэр намайг юуны тухай яриж байгааг сайнаас сайн ойлгосон. Тэр гарыг маань тавиж хойшоогоо ухрав. тэгснээ инээв. "Тэгвэл би чамайг баярлуулах уу, Ирэнэ? Би чамд огтоос ч хайргвй шдээ. Чамайг ийм юм хийсэнд гомдох ч vгвй байна. Би өөр эмэгтэйд хайртай. Би vнэндээ баярлаж байна". гэж тэр хэллээ.

"Чи баярлаж байна уу? Гэнри?"

"Vнэхээр ихээр баярлаж байна. Гэхдээ чамайг нэг их баяртай биш байгааг чин би харж байна ла даа."

"Vгвй дээ Гэнри, БИ сэтгэл дундуур биш байна. Бvх юм зvгээр."

"Нээрэн vв? за за газар хэвтээд байлгвй босч vз дээ." гэж хэлээд тэр дахиад өрөөг тойрон холхиж эхэлснээ "над руу битгий хар! Чи над руу харах ч эрх байхгвй шvв! Би хориглож байна." гэж хашгирав. БИ толгой унжуулж "би харахгвйээ Гэнри" гэж хэлэв.

"Үгвй чи харах болно. Чи өөрийгөө харах болно." гэж Гэнри хамаг чангаараа хашхираад гараас минь татан намайг том шилэн хаалгатай тавиурын өмнө аваачив. "Даашинзаа хар даа чи!". Хар улаан өнгөтөй дарс мөнгөлөг даашинзыг минь бүрхэн урсчээ.

"Чи тэрэнд хайртай болсон, чи түүнтэв явсан, одоо яая гэхэв. Гэтэл энэ дарс, энэ үнсэлтүүд, тэр олон нийтийн газар биеэ авч явж байгаа байдал..." Би юу ч хэлсэнгүй. Миний төлөвлөгөө бүтэмжтэй болжээ.

гэнри ч хэсэг дуугвй суусны эцэст тайван боловч хвйтэн өнгөөр

"Чи одоо бид 2ын хооронд юу ч байхгвй гэдгийг ойлгож ав! Угаасаа тийм юм хэзээ ч болоогвй байсан нь дээр байсан юм. Чи ч би чиний нөхөр байсныг мартаж хэрэгтэй. Тийм учраас надаас чамд хадгалагддаг юм бүхнийг чи надад буцааж өг! мэд ээ!" гэж хэлэв.

"Би одоо өгнөө, Гэнри."

Би дээшээ өрөө рүүгээ явж бүх зүйлсийг авчрав, түүний зурагнууд, түүний бэлэгнүүд, хэдэн захиа гээд л миний түүнээс авсан бүх юмс. Тэр миний авчирч өгсөн бүх юмсыг аваад гал руу шидчихэв.

"Би энийг авч үлдэж болох уу?" гэж би түүний хамгийн сайхан нэгэн зургийг нь гартаа барин асуулаа. Гар маань чичирч байв. Тэр нөгөө зургийг хараад, зургийг авч газар чулуудав. Би түүнийг нь газраас авч элгэндээ тэврэв.

"Тэгээд Зуулаа аль болох хурдан гэр бүлээ цуцлуулах хэрэгтэй." гэж Гэнри хэлээд галын хажуу дах сандал дээрээ суунгаа "Намайг ганцааранг маань орхиотох." гэв.

Би буцаж хаалга руу явж байгаад гэнэт зогссон. Түүн рүүгээ харсан. Тэгээд түүндээ бодож явснаа хэлсэн. Тайвнаар... "Намайг уучлаарай Гэнри... хэрвээ чи чадвал... тэгээд намайг мартаарай... Муухай бодлоор сэтгэлээ зовоож байгаад хэрэг байхгвй. Клэйр-н тухай бодож баяртай байгаарай! Миний тухай биш түүний тухай бодоорой. тэгсэн нь дээр."

Тэр над руу эргэн харж "Чи уг нь ийм л байсан шүү дээ өмнө нь" гэсэн.

"Би тийм байсан. Одоо гэхдээ би тийм биш. Бvх юм өөрчлөгддөг шvv дээ. Гэнри... Бvх юманд төгсгөл гэж байдаг. Гэхдээ амьдрах сайхаан... Амьдрах агуу юм. Чи маань харин жаргалтай байх ёстой шуу Гэнри."

"Ирэнэ ээ! надад яагаад өөрчлөгдсөнөө хэлээч!" гэж намуухан хэлэхийг нь сонсох надад амар байгаагүй. Миний нэр, бас энэ ганц өгvүлбэр намайг гацааж орхив. Гэхдээ зөвхөн нэг л хором.

"Би чадаагүй юмаа. Тэсч чадаагүй юм, Гэнри" гэж би намуухнаар хэлээд дээшээ өрөө рvүгээ гарсан.

Уруундуу орохдоо би уруулаа хэтэрхий чанга хазсанаас болж аманд мин цус амтагдаж байлаа. "энэ чин юу ч биш... энэ чин юу ч биш, Ирэнэ" гэж би өөртөө дахин дахин хэлж байлаа. яагаад ч юм бэ, би ярих хэрэгтэй байлаа. Сэтгэл дотор бөглөрөөд байгаа тэр юмийг vгээр л живvүлж чадах юм шиг надад санагдаж байв. "ирэнэ... энэ чин юу ч биш... дахиад ганц хором тэсчих... энэ бvгд дуусна... энэ чин юу ч биш..." гэж би өөртөө давтан давтан хэлж байлаа. Би өөрийгөө сохорчихоогүй гэж мэдэж байсан ч гэсэн нvд маань юу ч харахгүй байлаа. чих маань ч юу ч сонсоогүй. хэсэг хугацааны дараа арай гэж ухаан орон юм сонсож эхлэнтvүтээ би өөрийгөө "дахиад нэг хором... дахиад нэг хором..." гэж дахин дахин давтаж байгаагаа сонссон юм. гарт маань байсан Гэнригийн зураг газар унав. Би тvүнийг харлаа... тэгэхэд л би чухам яг юу болсон, юу болоод байгаа, юу болох гэж байгааг тодорхой томруунаар харсан юм. Энэ бvхэн нэг хоромоос ч хурдан хугацаанд болж өнгөрсөн юм... яг л

цахилгаан цахиад өнгөрөх шиг... хоолойд чин халуун төмөр тээглэсэн мэт болчихоод болсонгвй би хамаг чангаараа хашгирав... Одоо бодохнээ би тэгэхэд зүгээр ч нэг хашгираагвй юм. надаас гарсан тэр дуу хvний дуу биш шархадсан амьтны амьдрал гуйсан хоосон архираа байсан юм шиг...

Яг энэ нөчид Гэнри дээшээ хамаг хурдаараа гvйж ирэн хаалга тогшиж, "яасан, юу болов?" гэж хамаг байдагаараа хашхирав.

"Зүгээрээ! Би хулгана хараад " гэж аль болох тайван дуугаар хэллээ.

Би хөдлөхийг оролдсон ч газар хөлийн маань доор эргэлдээд болсонгвй. Доошоогоо л унаад байсан. Өрөөг маань хурднаар эргэлдэх хар утаа бvрхсэн мэт... Би уналаа...

Хичнээн ч хугацаа өнгөрсөн юм бvв мэд бvдээ нээхэд маань би газар хэвтэж байлаа. Өрөө хав харанхуй, бас нилээд жихvвн байх аж. Цонх онгорхой, хөшиг нь салхинд зөөлөн тийрvвлж хөдлөнө. "Би чинь ухаан алдчихсан байжээ." гэж би өөртөө хэлээд хөл дээрээ босохыг оролдов. Өвдөг маань хугарчихсан юм шиг өвдөж би өөрийн эрхгvй дахин газар уналаа. Би тэгээд газар хэвтэж байгаа тvвний зургийг харлаа... Цахилгаан биеээр маань гvйгээд өнгөрсөн.

Би зургийг авч тvшлэгтэй сандал дээр тавиад өөртэйгээ ярьж эхлэв. Одоо харин дуу маань хvний дуу шиг намуухан, сул дорой ч гэмээр болжээ. "Гэнри... Гэнри... Миний Гэнри... Энэ чинь юу ч биш шvв дээ. Энэ бу;гд худлаа тийм ээ, Гэнри? Энэ магадгvй зүгээр л зvвд байх... бид 2 удахгьи хамтдаа сэрнэ тийм ээ? Тэгээд л би уйлахаа боличихно. Нvд рvв маань битгий хараарай Гэнри. Би уйлж байгаа юм биш... одоо нэгхэн хормын дарааа энэ бvгд дуусна.... Хэдий энэ зvвд ч гэсэн надад хэцvв байна шvв дээ.... гэхдээ энэ бол юу ч биш... Чи надтай хамтдаа биз дээ... Гэнри... Чи бvгдийг мэдэж байгаа даа... Чи мэднэ шдээ... Би ер нь шал тэнэг байгаа биз? тийм гэж хэл л дээ, Гэнри... Инээмсэглээч дээ... Намайг

шоолж бvvр инээ... юу ч болоогvй байхад чин ингэж өөрийгөө зовоож байгаа надаар даажигнаж хөхрөөч! юу ч болоогvй байхад... Юу ч болоогvй шvv дээ... Би инээмсэглэж байгаа биз дээ.... хар даа... Чи надад хайртай тээ... Чи бол ганцхан миний Гэнри... Би жаахан ядарчээ, Гэнри... Гэхдээ би одоо амарлаа... Тэгээд энэ бvгд дуусна... Үгvй би уйлаагvй байна. Би чамд хайртай, Гэнри... "

Том, хvнд, чимээгvй нулимс хацрыг маань даган урсаж байлаа. Би уйлаагvй, гэхдээ... Би ямар ч цурхирах дуу гаргаагvй. И юм ярьж, инээмсэглэж байлаа. нулимс маань л эцэс төгсгөлгvй урсаж байсан юм даг.

Тvvний дараагийн сард яг юу болсныг би сайн санадагvй юм. Гэнри бид 2 гэр бvлээ цуцлуулсан. Эхнэрийн vнэнч бус байдлаас болж гэж тэр цаасан дээр бичнэ лээ. гэр бvл цуцлалтын шийдвэр гартал би Гнэригийн амьдарсан ч бид 2 нэг их олон тааралддаад байдагvй байсан юм. Хааяа нэг тааралдахаараа зvгээр мэндлээд л өнгөрдөг байв.

Би яж ийгээд амьдарч дөнгөсөн юм. Маш олон ном уншсанаа санаж байна. Маш олон ном... гэхдээ одоо би тэр номнуудаас нэг үг ч сананд ордоггүй юм. Ямар нэртэй ямар ном байсан... ёстой бvv мэд... Би гадуур их явдаг байлаа. хамгийн ядуучууд амьдардаг, намайг хэн ч олж харахааргүй захын гудамжнуудаар яваад л байдаг байсан. Гэхдээ би тэр үед жаахан ч гэсэн тайвширдаг байлаа. тэр үеийн юмнууд ч гэсэн бүдэг бадаг л толгойд маань байдаг юм. Нэг удаа намайг нэг хvvхэд заагаад "Энд нэг эргvv явж байна." гэж хэлснийг санадаг юм...

Би Гералд Грэйтэй ойр ойрхон уулзалддаг байсан... уулзаад сээтэгнэлцэнэ... аль болох ойрхон... би тэгэх ёстой байсан тул өөрийгөө чадахаараа хvчилдэг байлаа. Гэхдээ би бас л нэг ч удаагийнхаа болзоог санахгүй байна. Би яавч өөрийнхөө дvрийг сайн бу;тээсэн байж таарна. Нэг удаа надад Грэй "Хатагтай Стаффорд, та энэ дэлхийн хамгийн өвөрмөц, хамгийн их увидастай эмэгтэй. танай нөхөр тань ёстой тэнэг... гэхдээ би тvvнд нь ч баяртай байна л даа." гэж хэлсэн юмдаг. Би яг яаж энэ бу;гдийг хийснээ мэдэхгүй гэхдээ л ухаангүй байхдаа би болгосон л юм.

Тэр өдрvvдээс миний санаж байгаа ганц юм бол Гэнри. Би тvvнийг дандаа хардаг байв. Тэр бvх цагаа клэйртэй өнгөрөөж байлаа. Нvдэнд нь аз жаргалын туяа татаж, vргэлж инээмсэглэж явдаг болсон байв. Би тvvний нvvрнийх нь хувирал бvрийг уншиж чаддаг болсныхоо хувьд гэнри-г ямар их жаргалтай байгааг шууд л мэдэж байлаа. Тэр сvvлийн хэдэн сар тvvнийг дагасан хамгийн хэцvv хар дарсан зvvднээс сэрээд дахиад амьдрал амсаж байгаа шиг л харагддагсан. урьдын адил залуухан, хvчтэй, vзэсгэлэнтэй сайхан Гэнри... Дэндvv vзэсгэлэнтэй дээ, чи минь... Би Клэйрийг ч бас ажигладаг байлаа. тэр Гэнри-д ямар ч гэсэн хайртай байсан. Энэ бvхэн зvгээр л нэг сээтэгнл юм уу тvvний өөртөө итгэх итгэлийг нь тэжээх хоосон ялалт биш, гvн гvнзгий сэтгэл байсан юм. магадгүй тvvний анхны хайр нь ч байсан байж мэднэ. Клэйр зvгээр нэг хоосон хусэл тачаал биш ухаалаг, дээд гарлын, тогцон бvсгvй байлаа.

Ухаан үзэсгэлэн 2 нь яг л адил... хэмжээлэшгүй... Гэнри жаргана аа... Би нэг удаа тэднийг гудамжинд алхаж явахд нь харж билээ... Тэд хооронд ярилцаж инээмсэглэж байлаа. Клэйр гоёмсог цагаан хослол өмссөн байсан шиг санаж байна. юутай ч тэр 2 учиргүй жаргалтай харагдаж байж билээ.

Хотынхон маань гэр бүл салалтыг үзэж чаддаггүй байсан юм. Тэгхээр мэдээж намайг юу гэж ярьж байсан нь ойлгомжтой. Ямар ч гэр бүл намайг гэртээ оруулахаас татгааж, төвөгшөөх болсон юм. Гудамжинд хүн амьтан мэндлэхээ ч больсон. Найз маань гэгддэг байсан хүмүүсийн нүүр нь гутамшиг жигшил дүүрсэн хоосон инээд дүүрэн байдаг байлаа. Би нэг удаа Хатагтай Броган-тай тааралдсан юм. тэр намайг шинжгүй харснаа "Чи бохир амьтан! Чамайг Грэй-н мөнгөнд нь шунаж өөрийгөө худалдсаныг хэн ч мэдэхгүй гэж санаж байна уу? Гайгүй байлгүй" гэсэн. Пацы Тиллинс хэд хоногийн дараа гудманд тааралдаад "Хонгорхон минь чи ч буруу наймаа хийлээ дээ. Би аль ч ертөнцөд байсан Гэнри Стаффорд-г юугаар ч солихгүй байсан юм." гэж билээ...

Ингээд гэр бүлээ цуцлуулах өдөр ирэв. ... Би дахиад л Ирэнэ Вилмэр боллоо. Нөхөртөө үнэнч байж чадаагүйгээс болж салсан Ирэнэ Вилмэр. Тэгээд л болоо! Салахдаа Гэнри надад өгөх мөнгөнийхөө тухай ярьж эхлэхэд би юу ч авахгүй гэдгээ тодорхой хэлээд "Ноён Грэй чамаас илүү мөнгөтэй." гэж билээ. Гералд Грэй тэр өдрийн маргааш нь Нью Йорк

явах байсан юм. тэндээсээ Еврөп руу усан онгоцонд суух, би хамт явах ёстой байлаа.

Тэр орой Ноён Барнэс намайг дуудлаа. тэр сүүлчийн нэг сар хотоос гадуур байсан бөгөөд дөнгөж өнөөдөр л буцаж ирсэн байлаа. Тэгээд дхамаг юмыг сонсчээ.

"За Ирэнэ минь Би маш сонин юм сонссон. чи надад тэр тухай ярих уу?" гэж тэр хоолойгоо чичрүүлэн байж хэлж билээ.

"яасан гэж Ноён Барнэс. Ямар ч сонин хачин юм энд байхгүй гэж би бодож байна. Би саяхан Гэнри-с салсан." гэж би тайвнаар хариулсан.

"гэхдээ... ммм... Энэ бүгд нээрээ чиний буруугаас болж гэж үү? Чи үнэхээр буруутай юм уу?"

"хэрвээ та үүнийг гэм буруу гэж дуудмаар байвал тэг л дээ. Би Гералд грэй-д хайртай. тэгээд л тэр." Ноён Барнэс-н царай нь эхлээд улаан, дараа нь хөх дараа нь цав цагаан болов. Тэр удаан дуугүй зогссоны эцэст

"Чи нөхөртөө хайргүй юм уу?" гэж асуусан.

"Та Гэнри Стаффордын тухай ярьж байна уу? тэр одоо миний хөхөр байхаа нэгэнт больсон. тэгээд ч би түүнд хайргүй."

"Ирэнэ..." гээд тэр цаас нь үргэлжлүүлэх гэсэн боловч нэг л болж өгөхгүй байгаа нь илт. "Ирэнэ... энэ бүгд үнэн байж яасан ч таарахгүй. Чамайг ийм юм хийгээгүй гэдгийг чин би хүн бүрт хэлнэ."

"Би чин бурхан биш шүү дээ..."

Тэр буцаж ухраад саарал толгойгоо харамсалтайгаар сэгсэрч "Ирэнэ, чи нөхөр шигээ хүнийг тэр тэнэг залуугаар солих ч хүн биш дээ." гэж цөхөрсөн дуугаар хэлж билээ.

"Би тэгсээн, сольсон."

"Чи, Ирэнэ, чи. Би итгэж үнэхээр чадахгүй нь ээ!"

"битгий итгэ л дээ. Хэнд хамаатай юм." гэж намайг хэнэггүй хэлэхэд Ноён барнэс дахиж энэ бүгдийг тэсэхээ больсон бололтой

"тийм бол Би юу хэлэх вэ? Ирэнэ. Баяртай ирэнэ" гэж тэр удаахан хэлэв.

"Баяртай" гэж би үл тоосон янзаар хариу хэлэв...Би цонхоор түүний цаашаа алхаж байгаа урьд урьдынхаасаа хүнд ядарсан харагдах дүрийг нь харж "Баяртай Ноён Барнэс... Баяртай.. Намайг уучлаарай..." гэж шивнэж байлаа.

Гэртээ хамгийн сүүлд хоносон тэр шөнө би маш орой унцан. байшин тэр чигтээ харанхуй болсон хойно би чимээгүйхэн доод давхар луугаа явсан. Маргааш аяггүй бол Гэнри-д баяртай гэж хэлж амжихгүй... Гэхдээ би түүнтэй салах ёсгүйцэтгэмээр байв. Би чимээгүйхэн унтлаганы өрөөний хаалгыг нээхэд гэнри тайван унтаж байлаа. Би орлоо. түүнийг харахын тулд цонхны хөшгийг жаахан нээж гэрэл оруулав. тэгээд нэгэн цагт минийх байсан орны хажууд зогслоо. Нүүр нь тайван бөгөөд дөлгөөхөн, хав хар сормуус нь хөдөлгөөнгүй, сайхан уруул нь харанхуйд цайрах нүүрэн дээр нь сийлсэн юм шиг үзэгдэлтэй харагдаж байв. Би түүнд хүрч зүрхлээгүй учраас гараа болгоомжтойгоор дэрэн дээр түүний толгойны хажууд тавьсан. Тэгээд би газар өвдөглөн сууж уруулыг нь хичнээн үнсэхийг хүссэн ч гэнри-г сэрэхгүйн тулд тэрийгээ дарж ядан сууж байлаа. Харин гарыг нь авч уруулдаа хүргээд "Гэнри... Чи юу хийснийг маань хэзээ ч мэдэхгүй...мэдэх ч ёсгүй... Аз жаргалтай амьдраарай! Харин би өөртэйгөө хамт нэг л зүйлийг авч явах болно. "Би Гэнри-д хайртай байсан" гэж хэлэх тэр эрхийг би өөртөө үлдээнээ. Чамайг үхэн үхтлээ хайрлах тэр эрхийг би авч явна." гэж зөөлхөн шивнэсэн. Тэгээд би босч, хөшгийг хаагаад гарч явсан. Маргааш нь жихүүн саарал өдөр байлаа. Хааяхан хүйтэн бороо асгаж, зөөлөн салхи хөгшин саарал үүлсийг тэнгэр авчирсан тийм л өдөр байсан. галт тэрэг орой 10.15-д явах байсан бөгөөд Ноён Грэй өглөө нь над руу залгаж намайг орой ирж авахыг хүссэн байлаа. Тэр аз жаргалаар бялхаж байгаа нь хэнд ч ойлгомжтой байсан юм. "Би өөрөө очиноо намайг харин буудал дээр хүлээж байгаарай!" гэж би хэлсэн.

Аль хэдийн харанхуй болсн ч би өрөөндөө ганцаараа суусаар л байлаа. Өөрөө ч гайхмаар тийм их цөхрөл намайг тойрно. Би Гэнри-г хвлээж байсан юм. Тэр хараахан гэртээ ирээгвй л байв. тэр Клэйр-нд очиж эрх чөлөөтэй анхныхаа өдрийг өнгөрөөхөөр явсан байсан байх. уг нь салах ёс хийх нэг их шаардлагагвй байсан ч гэсэн би вүрд явахынхаа өмнө твүнйиг хармаар санагдаад болохгвй байлаа. гэтэл Гэнри ирдэггвй... Би цонхны хажууд сууж хэдий хвйтэн байсан ч гэсэн онгойлгож гудамжийг харж суулаа. бороо цутгаж байшингуудын дээвэр, явган хвний замнууд гялалзаж харагдана. Хааяахан өнгөрөх явган хвмвүс бүгд л нэг тийшээ учиргвй яарсн шинжтэй, цөхөрсөн ганцаардмал ч юм шиг харагдаж байсансан... Аль хэдийн 9.30 болсон ч, Гэнри гэртээ ирсэнгвй. Би цонхоо хааж жижигхэн цвнхэндээ авч явах звйлсээ хийхээр суулаа. Надад боож баглаад байх сүртэй юм байсангвй: нэг даавуу, хуримийнхаа даашинз толгойвч 2ыг, ба Гэнри-н зураг. Ийм л хэдэн звйлтэй би тэндээс явсан юм. Цвнхээ дурамжхан хааж байтал хаалганд твлхвүр дуугарах чимээ, дараа нь твүнйи хөлийн чимээ сонсогдов. Тэр хврээд иржээ. Би малгай цув 2оо өмсөж, цвнхээ авангаа "Би вүдний хонгилоор өнгөрөхдөө ажлынх нь өрөөний хаалгыг нээгээд л харчихая. Ганцхан удаа.. Гэнри намайг анзаарах ч вгвй." гэж бодож байлаа. Ингээд би доошоо бууж, вүдний хонгилд очин Гэнри-н ажлын өрөөний хаалгыг онгойлгож хартал өрөө нь хоосон байна. Би ч одоо яая гэхэв гэж бодоод вүд рвү алхан хаалганы бариулыг атгах тэр агшинд Гэнри-н тайван

боловч гунигтай дуу "Ирэнэ, надад баяртай ч гэхгвй явах гэж байгаа юм уу?" гэх нь тэр. эргэн харвал Гэнри зогсож байлаа. Дэндүү их сандарснаас хамаг хяналтаа алдчих дөхсөн би гэдэг хvн "Аанхаа..." гэж утгагвй дуугаар хэлэв.

Би 2 тvvний ажлын өрөөнд орлоо. Зууханд гал асаажээ. Гэнри гуниг гялалзсан тод хар нүдээрээ над руу ширтэж "Ирэнэ, чи бид 2 vvpд салж байна. Магадгвй... Гэхдээ чи бид 2 нэг нэгэнтэйгээ учрах л хувьтай байсан шvv." гэв.

Бий дуугай л толгой дохилоо. Хэрвээ ямар нэг юм хэлчихвэл дуу хоолой маань хяналтнаас гарчих гээд хэцvv байсан юм.

"Би чамд ямар нэг бурууг тохохгвй ээ, чамайг муулах ч vгвй. Ирэнэ. Тэр орой зоогийн газар болсон явдал бол... чи өөрөө ч анзаараагвй галзуурал байсан байх. ямар ч гэсэн би чамайг тэр орой байсан эмэгтэй гэж бодохгвй байна."

"Магадгвй тийм биз... Гэнри..." гэж би тэсч чадалгвй шивнэв.

"Чи биш шvv дээ. Би чамайг vргэлж хайрлаж явсан тэр эмэгтэй чигээр чин лсэтгэл зүрхэндээ vлдээнэ." гээд Гэнри хэсэг дуугай болов. Би урьд нь хэзээ ч тvvнийг ийм цөхөрсөн, чимээгвй байхыг нь харж байгаагвй шиг санагдана.

"Амьдрал vргэлжлэх л болно. Би өөр бvсгvйтэй... чи өөр залуутай гэрлэнэ... тэгээд бvх юм мартагдана." гэж тэр маань vргэлжлvvлэн хэлээд гарыг маань атгана.

"гэхдээ чи бид 2 дэндүү жаргалтай байсан шvv!" гэж хэлэхдээ нүдэнд нь гэнэт гэрэл тусав.

"Тийм ээ Гэнри!" гэж би шулуухан бөгөөд тайванханаар хариулсан.

"Чи тэгэхэд надад хайртай байсан уу? Ирэнэ?"

"Аанхаа, хайртай байсан."

"Гэхдээ тэр цаг нэгэнт өнгөрч дээ... юутай ч би чамайг хэзээ ч мартагвй, Ирэнэ. Чадахгвй. Би чамайг бодох болно..."

"тэгээрэй Гэнри минь! ЗАримдаа намайг санаж байгаарай!"

"Чи жаргалтай байна биз дээ, Ирэнэ? Би чамайг жаргаасай гэж хвсч байна."

"тэгнээ Гэнри!"

"Би ч адилхан. Магадгвй чамтай байсан шигээ тийм их жаргалтай байж ч мэднэ. Гэхдээ одоо чи бид 2 эргэж харж болохгвй ээ! Хвн чин урагшаа харж амьдрах ёстой! Чи намайг жаахан ч гэсэн бодох уу? Ирэнэ"

"Тэгнээ, би бодно, Гэнри."

Тэрний маань нвд харанхуй гуньигаар дvvрсэн байхыг би харж байлаа. Би толгойгоо өргөж гараа Гэнри-н мөрөн дээр нь тавиад намуухан бөгөөд ихэмсэгээр "Гэнри, чи жаргах ёстой шvv! бас хвчтэй, ихэмсэг амьдрах учиртай. Гуниг харууслыг давж гарч чадахгвй тэр л хvmvvc гуниг харуусалтай амьдардаг. Чи бол амьдрал руу инээмсэглэж амьдрах хув;тай хвн."

"ЗА тийм дээ. Чиний зөв... бvх юм сайхнаар төгссөн шvv дээ. Энэ бvхэн чи бид 2ын аль нэгнийх нь амьдралыг баллаж болох л байсан шvv дээ! Тэгээгвйд нь би баярлаж байна." Хэсэг дуугвй суусны дараа Гэнри

"Ирэнэ минь баяртай! Чи бид 2 дахиж энэ хорвоо дээр ч бараг уулзахгвй биз дээ." гэж хэлсэн юм. Би одоо ч санаж байна.

"Амьдрал гэдэг чин богинохон шvv дээ, Гэнри" гэж хэлэхдээ би чичирч байсан. Гэнри-д анзааруулахгвйн тулд би "Гэхдээ хэн мэдэх вэ? бид 2 60 настайдаа уулзаж ч мэднэ шvv дээ." гэж хурдхан шиг хэлэв. Гэнри инээмсэглээд, "Магадгвй ээ! Тэгээд Зуулаа энэ бvгдийг ярилцаад инээж байхгвй юу!" гэв.

"Тийм ээ! Гэнри! Зуулаа инээлдэнэ."

Тэр толгойгоо гудайлгаж гарыг маань үнсээд "Яв даа одоо, чи миний амьдралд тохиолдсон хамгийн сайхан зүйл байсан шүү!, Ирэнэ." гэж доор дуугаар шивнэсэн. тэр толгойгоо өргөж нүд рүү маань хараад "надад эцсийн удаа ганц ч гэсэн юм хэлэхгүй юм уу?" гэхэд нь би түүнийхээ нүд рүү нь харж байгаад хамаг сэтгэлээсээ нэг л хариулт хэлсэн.

"Би чамайг хайрласан шүү, Гэнри!"

Гэнри гарыг маань дахин үнсээд "Би жаргалтай байх болноо. Гэхдээ хэзээ ч тэр эмэгтэйтэй учраагүй байсан ч болоосой гэж хүсэх үе ч надад ирнэ. Амьдрал чин хатуу шүү дээ" гэж сул дуугаар шивнэлээ.

"Тийм ээ Гэнри!" гэж би товчхон хариулсан...

Гэнри намайг өргөж үнсэж билээ. Түүний уруул нь миний уруул дээр, харин 2 гар маань түүний хүзвүг ороосон байсан. Хэзээ энэ хамгийн сүүлчин удаа байсан ч ямар ч гэсэн болсон юм. Одоо хэн ч надаас тэр хормыг булааж авч чадахгүй.

Гэнри надтай хамт гадаа гарлаа. Би хөлсний тэрэг дуудаж дотор нь суугаад, цаонхоор нь харахад тэр довжоон дээр зогссоор л байсан юм. Зөөлөн салхи үсийг нь үлээж, харин тэр хөшсөн адил зогсож байсан... Ингэж би хамгийн сүүлчийн удаа түүнийг харсан юм.

Нүдээ аниж нулимсаа залгиад хичнээн ч явсан юм бүү мэд. Ямар ч гэсэн нүдээ нээхэд маань такци аль хэдийн буудал дээр ирж зогссон байлаа. Би мөнгөө төлж, цүнхээ аваад галт тэрэг рүү явав.

Joined: 2005 Aug 01 09:48 pm

Posts: 299

Location: A man who believes in nothing is nothing. What you believe in is who you are... Гералд Грэй намайг буудал дээр хвлээж байлаа. Тэр гоёмсог аялалын хувцас өмсчээ. Гартаа барьсан дуу алдам сайхан цэцгээ надад өгөхдөө, баяртай инээмсэглэлээ нvvрнээсээ арчиж чадахгvй байсан юм. Бид нэг их юм ч ярьсангvй галт тэргэнд суулаа. 10.15-н ved галт тэрэг хөдлөж эхлэв. Харанхуй цонхны цаагуур буудлын байшингууд, босоо шонгууд, харанхуй гудамжнууд ээлж дараагаар жирэлзэн өнгөрнө. Ингээд хот бидний ард хоцорлоо. Галт тэрэгний дугуй өнхөрсөөр...

Бид 2 кабиндаа Зуулахнаа байв. Ноён Грэй над руу нууцхан харж инээмсэглэхдээ намайг хариуд нь инээмсэглэх болов уу гэж бодсон нь илт. Би харин огт амьгvй мэт суусаар байв. Грэй "Ингээд арай гэж нэг юм Зуулахнаа vлддэг байна шvv" гэж шивнээд намайг тэврэхийг оролдсон боловч би тvvнийг өөрөөсөө тvлхэн холдуулав.

"Байзнаарай, Ноён Грэй! Бид 2т хангалттай цаг байна шд" гэж намайг хvйтнээр хэлэхэд Грэй "Яасан бэ Хатагтай Стаффорд? Yгvй ээ! хатагтай Вилмэр. Та чин бvvр цонхийцон байх чин..." гэж vгээ зөөн асуулаа. "Яагаа ч vгvй ээ! Зvгээр л би жаахан ядраад" гэж би нөгөө л хvйтэн өнгөөр хэлэв.

БYтэн 2 цаг бид 2 чимээгvй, хөдөлгөөнгvй суулаа. Бидний эргэн тойронд байсан ганц чимээ гэвэл галт тэрэгний дугуй л байв. 2 цагийн дараа галт тэрэг маань анхныхаа зогсоол дээр зогссон бөгөөд би цvнхээ барин бослоо. "Хvve, та чин хаачих нь вэ?" гэж Ноён Грэй дуу нь цахиртан асуухад би юу ч хэлсэнгvй буув. Галт тэрэгнээс буусныхаа дараа би Грэй-н сууж байсан кабин-н онгорхой цонхон дээр ирж "За Ноён Грэй. Намайг нэг саятан САН Франциско-д хвлээж байгаа. Би таныг зvгээр л нөхрөөсөө салахын тулд ашигласан юм. Баярлалаа. Харин энэ тухай та хvнд vг хэлээд хэрэггvй биз дээ. Эс тэгвээс бvгд таныг шоолон хөхрөх болно шуу дээ." гэж хэллээ. Тэр амаар ангайн гацчихсан... Сэтгэл нь ямар их дундуур байсныг би шууд хараад л мэдэж байв. Гэхдээ жинхэнэ эр хvний зан

гаргаж надад тэр бүх сэтгэл тавгвйцэлээ үзүүлсэнгвй. Харин "Танд тэгж тус болж чадсан бол би баяртай байна." гэж эелдэгээр хэлж чадаж билээ, Грэй. Яг энэ нөчид галт тэрэг хөдлөж, Грэй малгайгаа аван над руу даллаад алга болов.

Ингээд би тэр нэг буудал дээр ганцаарааа хоцорсон. Хүн хүнд үйлс удаахнаар хөвсөн нил хар тэнгэр намайг бүрхжээ. МИний санаж байгаагаар тэнд хуучин хашлага бас унжиж норсон модод, нойтон навчис л байсан шиг... Харин тасалбар түгээх цэгийн цонхоор нь бүдэг гэрэл сүмэлзэж байлаа. Надад их мөнгө байсангвй. Би гэрэл сүмэлзэх цонхон дээр очиж байгаа бүх мөнгөйө сарвайгаад "Надад нэг тасалбар өгөөч!" гэж хэлэв. Тэндэхийн жайлчин нь нэг хялайж хархчихаад "Аль буудал руу вэ?" гэж товчхон асуухад нь би "Аль нь ч хамаагвй ээ!" гэлээ.

"ЗА та хэлээдэхээч..."

"Энэ шугамны хамгийн сүүлчийн буудал хүртэл..."

Ажилчин залуу нэг тасалбарыг миний мөнгөний хагастай буцааж түлхээд сонин харцаар намайг ширцээр хоцров.

Галт тэрэг буудал дээр ирж зогсоход нь би "ямар ч хамаагвй нэг буудал дээр буучихна даа" гэж бодсоор дотогш оров. Би нэг цонхны хажууд суугаад дахиж хөдлөөгвй. Эхлээд цонх харанхуй байснаа гэрэлтэй болж дараа нь дахин харанхуй болсныг би санаж байна. Ямар ч байсан би 24 цагаас илүү л явсан болж таараад байгаан. Ёстой мэдэхгвй. Дахиад харанхуй нөмрөхөд би ямар нэг буудал дээр бууснаа санаж байна. Галт тэрэг зогссон... Би буусан... маш харанхуй ямар ч гэрэл үзэгдэхгвй байгааг мэдрээд буцаж галт тэргэнд суух гэсэн боловч галт тэрэг нэг хөдлөөд явчихаж билээ. Ингээд л нойрмог ажилчин, бүдэг гэрэлтэй мухлаг, өөрийгөө борооноос хамгаалахын тулд сандал доор хэвтэх нохойноос өөр юмгүй нойтон тавцан дээр үлдсэн дээ. Буудлаас цааш лавшруулан харвал нарийхан гудам бас хэдэн модон байшин харагдаж байлаа. Цагаа харвал өглөөний 3 цаг болж байв. Би сандал дээр суугаад өглөөг

хвлээхээр шийдэв... БУх юм өнгөрчээ... Би хийх ёстой юмаа хийлээ...
Амьдрал ингээд л дуусчихсан...

Joined: Би одоо тэр хотхонд амьдардаг юм. Жижигхэн дэлгүүрт өглөө 9-с орой 7 хүртэл ажиллана. Би хамгийн ядуу нэгэн байшинд 2 өрөөг эзэгнэдэг, гэхдээ тусдаа шаттай болохоор намайг хэзээ яж гарч орж байгааг хэн ч анзаардаггүй юм. надад танил нөхөд энэ тэр гэж юм юу ч байхгүй. Би ажилдаа яг таг ханддаг ч хэзээ ч ярьж байгаагүй. Тийм ч учраас миний хамт ажилладаг хүмүүс нэрийг маань ч мэдэхгүй. Харин байрныхаа эзэнтэй сард нэг удаа төлбөрөө хийх гэж тааралддаг юм. Би ерөөсөө юм боддоггүй. Ажиллаад л гэртээ ирээд л идчээд унтдаг. тэгээд л болоо. Би уйлдаггүй. Заримдаа ойдог шилэн өөрийгөө харахад цонхийж цайсан нүүр, нүүрэндээ арай томдсон, энэ дэлхийн хамгийн тайван, чимээгүй 2 нүдийг л хардаг. Би гэртээ ч үргэлж ганцаараа байдаг. Харин Гэнри-гийн баяртай инээмсэглэсэн зураг ширээн дээр минь үргэлж байсаар ирсэн. Зурагны хүрэн дээр "Ирэнэ-дээ. Гэнри. Үүрд мөнх." гэж бичсэн байдаг юм. ядарсан ведээ би ширээний өмнө сөхөрч суугаад түүнийгээ удаан гэгч нь хардаг...

Хүмүүс цага хугацаа бүгдийг авч оддог гэж хэлэлцдэг. Тэр хууль надад гэхдээ үнэн байгаагүй. Он жилүүд өчнөөн төчнөөнөөрөө урссан ч би

Гэнри Стаффорд-д хайртай хэвээр л байсан юм. Одоо ч хайртай. Тэр маань одоо аз жаргалтай байгаа. Би түүнд аз жаргалыг нь авч өгсөн юм. Тэгээд л болоо. Намайг авааль нөхрөө худалдаж авсан гэж ярилцдаг хүмүүс магадгүй зөв байх. Би түүнийхээ амьдралыг нь, аз жаргалыг нь өөртөө байгаа бүх юмаараа төлж байж худалдаж авч өгсөн. Би Гэнри-д хайртай. Хэрвээ бурхан надад дахиад амьдрах боломж олгосон бол би яг л өөрийнхөө хийснийг ямар ч эргэлзээгүйгээр хийх байсан.

Бүсгүйчүүд, охид оо! Намайг сонсох хүн бүрт би хэлье! Хэзээ ч хүнийг ухаан санаанаасаа илүү бүү хайрлаж бай! Хайраас өөр ямар нэг зорилго, хүсэлтэй бай. Хайрандаа заавал хязгаар тавь!... Хэрвээ чи чадвал шүү дээ... Би бол чадаагүй.

Хүн үхэн үхтлээ амьдрах учиртай. Тэгээд ч би амьдарсаар байна. Гэхдээ энэ амьдрал маань нэг их удахгүй болсныг би мэдэрч байна. Төгсгөл ирж явааг би харж байгаа. би өвчтэй зовлонтой биш ч миний хууч чадал, амь маань дотроосоо унтарч байгааг би мэдэрч байна. Өнгөрсөнд болж өнгөрсөнд би огтоос ч харасдаггүй. Дараа нь юу болохоос айдаг ч үгүй. Амьдралаас хүсэх ганцхан л юм надад үлдсэн: би Гэнри-г дахиад нэг л удаа харчихмаар байна. Миний бүхэл амьдрал маань болсон тэр хүнийг би ганцхан удаа эцэсийн ганц удаа хармаар байна. Ганцхан удаа... Би нэгэнт хотдоо буцаж чадахгүй учраас залбираад л хүлээгээд байдаг. Би уньхээр утга учиргүй ихээр залбирч хүсдэг. Одоо надад нэг их ч цаг үлдээгүй байна.

Гудамжаар алхан явахдаа би зөрөн өнгөрөх хүн бүрийг ажилглан хардаг. Орой нь гэртээ ирчихээд Гэнри-гийн зургийг харж "Өнөөдөр биш байнаа, Гэнри минь. Магадгүй маргааш..." гэж шивнэнэ.

Би дахиад түүнтэй уулзах, түүнийг харах болов уу? Би өөртөө тэгнэ гэж хэлдэг ч дотроо тэгэхгүй гэдгээ мэдэж байдаг...

Ингээд би өөрийн тvvхээ бичэж дууслаа. Хамаг сэтгэлээ чангалан байж бичэж дуусгалаа. Хэрвээ Гэнри vннийг маань унших юм бол тэр ямар ч гэсэн сэтгэл дундуур байхгvй биз. Харин тэр маань бvгдийг нь ойлгоно.

Тэгээд энэ бvгдийг уншихаад тэр магадгvй... vгvй ээ... тэр надтай уулзах гэж ирэхгvй. ТИЙМ юм хийх ёсгvй гэдгээ тэр ойлгож байгаа. Харин тэр гудамжинд надтай зөрөөд л өнгөрөх болно. Намайг огт анзаараагvй юм шиг. Харин би дахиад ганцхан удаа... эцсийн удаа тvvнийгээ харна...

Төгсөв.

1926 Чикаго.

Эх сурвалж: www.asuult.net/forum